




ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТ БИЧГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

## АГУУЛГА

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>4</b>
<b>ТАЛАРХАЛ</b> .....	<b>5</b>
<b>СУДАЛГААНЫ БАГ</b> .....	<b>6</b>
<b>ХҮСНЭГТ, ЗУРАГ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>8</b>
<b>ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ</b> .....	<b>12</b>
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b> .....	<b>14</b>
1.1. Үр нөлөөний үнэлгээний зорилго, зорилт .....	14
1.2. Хамрах хүрээ.....	14
1.3. Арга зүй, аргачлал.....	15
1.3.1 Судалгааны ерөнхий загвар.....	15
1.4. Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулсан арга .....	18
1.5. Судалгааны зохион байгуулалт .....	19
1.6. Тайлан боловсруулахад ашигласан программ хангамж.....	19
1.7. Судалгааны хяналтын үе шатууд .....	19
1.8. Үр нөлөөний үнэлгээг хийхэд учирсан хүндрэл, бэрхшээл.....	20
1.9. Судалгааны хязгаарлагдмал байдал .....	20
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>22</b>
2.1. Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл .....	22
2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөртэй холбоотой төрийн байгууллагаас үйлчилгээ авахад учирсан хүндрэл, бэрхшээл .....	24
2.3. Мэдээллийн эх сурвалж .....	26
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ҮР ДҮН, ҮНЭЛГЭЭ</b> .....	<b>29</b>
3.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөрүүдэд хийсэн дүн шинжилгээ.....	29
3.2. Бодлого, хөтөлбөрүүдийн ач холбогдол .....	35
3.3. Бодлого, хөтөлбөрүүдийн үр дүн.....	37
3.4. Бодлого хөтөлбөрүүдийн үр ашиг .....	42
3.5. Бодлого, хөтөлбөрүүдийн тогтвортой байдал.....	45
3.6. Бодлого, хөтөлбөрүүдийн сайн туршлага ба сургамж.....	47
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ</b> .....	<b>51</b>
4.1. Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал .....	51
4.1.1. Дотоод эдийн засгийн тойм мэдээлэл.....	51
4.1.2. Гадаад худалдаа.....	53
4.2. Монгол Улсын эдийн засагт ХАА-н салбарын үзүүлж буй нөлөө.....	55
4.2.1. ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзэлж буй хэмжээ .....	55
4.2.2. ХАА-н салбарт ажиллагсдын мэдээлэл .....	55
4.2.3. ХАА-н салбарын голлох үйлдвэрлэлийн тухай .....	56
4.2.4. ХАА-н салбарын бүтээгдэхүүний экспортын хэмжээ .....	58
4.3. Бодлого, хөтөлбөрийн үр шим хүртэгчдэд үзүүлсэн үр нөлөө .....	59
4.3.1. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө .....	59
4.3.2. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө.....	60
4.3.3. "Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөрийн үр нөлөө .....	61
4.3.4. "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн үр нөлөө .....	63
4.3.5. "Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийн үр нөлөө.....	64
4.3.6. "Ноолуур" хөтөлбөрийн үр нөлөө.....	65
4.3.7. "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийн үр нөлөө .....	66
<b>ТАВДУГААР БҮЛЭГ. ҮР НӨЛӨӨ ХҮРТЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ</b> .....	<b>69</b>

5.1. Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ болон GAP шинжилгээ .....	69
5.1. Үр нөлөө хүртэгчдийн бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаанд өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ .....	71
5.1.1. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын сэтгэл ханамжийн үнэлгээ .....	72
5.1.2. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын сэтгэл ханамжийн үнэлгээ	73
5.1.3. Хөтөлбөрүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээ.....	75
5.2. Үр нөлөө хүртэгчдийн төрийн үйлчилгээнд өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ.....	78
5.2.1. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	78
5.2.2. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	81
5.2.3. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	85
5.2.4. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ	88
5.2.5. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	91
<b>ДҮГНЭЛТ.....</b>	<b>96</b>
<b>БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ .....</b>	<b>99</b>
<b>САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>114</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....</b>	<b>115</b>
<b>ХАВСРАЛТ -1 “ТҮҮВЭР СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ХУУДАС”-НЫ ЗАГВАР.....</b>	<b>116</b>
<b>ХАВСРАЛТ -2 “ЧАНАРЫН СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ХУУДАСНУУД” .....</b>	<b>122</b>
<b>ХАВСРАЛТ -3 “СУДАЛГААНЫ ЗОРИЛТОТ БҮС НУТАГТ АЖИЛЛАСАН БАЙДАЛ” .....</b>	<b>126</b>
<b>ХАВСРАЛТ -4 “БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД” .....</b>	<b>128</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АА	Аж ахуй
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МАА	Мал аж ахуй
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУБ	Олон улсын байгууллага
ХБ	Хөгжлийн банк
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага

## ТАЛАРХАЛ

“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”-ны захиалгаар гүйцэтгэсэн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөрийн баримт бичгийн үр нөлөөний үнэлгээ”-ны ажлыг хийхэд санхүүжилт олгосон, судалгааны арга зүйг нарийвчлахад зөвлөгөө өгсөн, судалгааны талбарт мэдээлэл цуглуулагчаар ажилласан, судалгаанд хамрагдсан бүх байгууллага, хувь хүмүүст талархал илэрхийлье.

Та бүхний хичээл зүтгэлээр энэхүү судалгааны ажлын үндсэн мэдээлэл цугларч, амжилттай тайлан бичих боломж бүрдсэн билээ.

Энэхүү судалгааны тайлан нь үндсэн 5 бүлэгтэй ба эхний бүлэгт судалгааны арга зүй, зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй оруулав. Хоёрдугаар бүлэгт судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, гуравдугаар бүлэгт бодлого, хөтөлбөрийн үр дүнгийн талаар, дөрөвдүгээр бүлэгт бодлого, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлсэн үр нөлөөний талаар, тавдугаар бүлэгт үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүнг тус тус орууллаа. Харин төгсгөлд нь дүгнэлт, санал зөвлөмжийн хэсэг болон хавсралт материалыг оруулсан.

Судалгааны үр дүнтэй холбоотой санал хүсэлт, анхаарах асуудал байвал бидэнд мэдэгдэж, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна. Та бүхний санал бидний дараа дараагийн ажлуудад том дэмжлэг болох юм.

Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар хөгжин цэцэглэж улс орны эдийн засагт томоохон дэвшил, боломжийг бий болгох болтугай.

**СУДАЛГААНЫ БАГ**

Энэхүү тайланг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн төрийн бодлого, зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүн, ХХААХҮЯ, Орон нутгаас иргэдэд үзүүлж буй ажил, үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийг судлан дүгнэлт хийж, бодлогын зөвлөмж боловсруулах, цаашлаад судалгааны ажлын үр дүнг ашиглан хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг сайжруулах, боловсронгуй болгох, оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлох үндсэн зорилгын хүрээнд хийж гүйцэтгэв.

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” эзэмшинэ.

**Судалгааны багийн ахлагч:**

С.Хандсүрэн “Эс Ай Си Эй” ХХК - ийн зөвлөх, Доктор, Дэд профессор

**Судалгааны зөвлөх:**

Г.Эрдэнэ “Эс Ай Си Эй” ХХК – ийн Дэд захирал, Докторант

**Судлаачид:**

Э.Должин “Эс Ай Си Эй” ХХК – ийн Нийгэм, эдийн засгийн хэлтсийн захирал, Докторант

Т.Амаржаргал “Эс Ай Си Эй” ХХК – ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтсийн менежер

**Мэдээлэл цуглуулалтын баг:**

Х.Долгормаа “Эс Ай Си Эй” ХХК – ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн захирал, Магистр

Э.Нямдаваа “Эс Ай Си Эй” ХХК – ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн ахлах менежер

Б.Төрцэцэг “Эс Ай Си Эй” ХХК – ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн менежер

Э.Пүрэвжав “Эс Ай Си Эй” ХХК – ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн менежер

Г.Оргилмаа “Эс Ай Си Эй” ХХК – ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн менежер

Х.Сарангоо “Эс Ай Си Эй” ХХК – ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн хянагч судлаач

**Мэдээлэл цуглуулагчид:**

М.Жуудай “Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

О.Анужин “Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

Г.Цацрал “Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

Г.Сэлэнгэ “Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

Д.Замбуулин “Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

А.Энх-Амгалан “Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

н.Аззаяа “Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

Б.Дөлгөөннaран	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
С.Буяндэлгэр	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
Ч.Одгэрэл	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
Ж.Отгонзаяа	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
Б.Энхбаяр	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
Э.Мөнгөнтуул	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
Ц.Онон	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
Б.Номин-Эрдэнэ	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
П.Болорцэцэг	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
А.Буянзаяа	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач
Г.Хэрлэн	“Эс Ай Си Эй” ХХК – ийн Гэрээт судлаач

## ХҮСНЭГТ, ЗУРАГ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээ хийх аргачлал.....	16
Хүснэгт 2. Судалгааны төрөл.....	18
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	22
Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын төрөл, <i>хөтөлбөр тус бүрээр</i> .....	23
Хүснэгт 5. Бодлогын баримт бичгүүдийн дүн шинжилгээ.....	30
Хүснэгт 6. ХАА бүтээгдэхүүний үйлдвэрлэл, <i>мянгаар</i> .....	57
Хүснэгт 7. Үндэсний хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ.....	75
Хүснэгт 8. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын үр нөлөө.....	99
Хүснэгт 9. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын үр нөлөө.....	102
Хүснэгт 10. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө.....	104
Хүснэгт 11. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө.....	106
Хүснэгт 12. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө.....	108
Хүснэгт 13. “Ноолуур” хөтөлбөрийн үр нөлөө.....	110
Хүснэгт 14. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө.....	111
График 1. Үйлчилгээ авахад учирсан хүндрэл, бэрхшээл, $n=1,500$ .....	24
График 2. Ямар хүндрэл, бэрхшээл учирсан талаарх сэтгэгдэл, $n=221$ .....	25
График 3. ХХААХҮЯ болон харьяа байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд ямар арга хэмжээг авах нь тохиромжтой гэж үзэж байна вэ?, $n=1,500$ .....	26
График 4. Мэдээллийн эх сурвалж, $n=1,500$ .....	27
График 5. Бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй боловсон хүчин, холбогдох ажилтнууд танд хэр сайн мэдээлэл өгдөг байсан бэ?, $n=1,500$ .....	27
График 6. Салбарт баримталсан бодлого, хөтөлбөрийн мониторинг үнэлгээний дүн, <i>хувиар</i> .....	29
График 7. Бодлого, хөтөлбөрүүдийн ач холбогдол.....	35
График 8. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэр ач холбогдолтой байсан бэ?.....	36
График 9. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр ач холбогдолтой байсан бэ?.....	36
График 10. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр ач холбогдолтой байсан бэ?.....	37
График 11. Бодлого, хөтөлбөрүүдийн үр дүн.....	38
График 12. Үр нөлөөний үнэлгээг ХХААХҮЯ-ны ХШҮ-ний дүнтэй харьцуулсан үр дүн.....	38
График 13. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэр үр дүнтэй байсан бэ?.....	39
График 14. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр үр дүнтэй байсан бэ?.....	39
График 15. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр үр дүнтэй байсан бэ?.....	40
График 16. Бодлого, хөтөлбөрүүдийн үр ашиг.....	43
График 17. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэр үр ашигтай байсан бэ?.....	43
График 18. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр үр ашигтай байсан бэ?.....	44
График 19. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр үр ашигтай байсан бэ?.....	44
График 20. Бодлого, хөтөлбөрүүдийн тогтвортой байдал.....	45
График 21. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэр тогтвортой байдлыг хангаж ажилласан бэ?.....	46

График 22. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр тогтвортой байдлыг хангаж ажилласан бэ? .....	46
График 23. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр тогтвортой байдлыг хангаж ажилласан бэ?.....	47
График 24. Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр, <i>тэрбум төгрөгөөр</i> .....	51
График 25. Инфляцын түвшин .....	52
График 26. Монгол Улсын төсвийн орлого, <i>бүтцээр</i> .....	52
График 27. Монгол Улсын төсвийн зарлага, <i>бүтцээр</i> .....	53
График 28. Гадаад худалдааны тэнцэл, <i>тэрбум ам.доллар</i> .....	53
График 29. Экспортын бүтэц .....	54
График 30. Импортын бүтэц.....	54
График 31. ХАА –н салбарын ДНБ –д эзлэх хувь.....	55
График 32. ХАА -н салбарт ажиллагсдын хувь.....	55
График 33. Дундаж цалин, <i>мянган төгрөгөөр</i> .....	56
График 34. Малын тоо, <i>сая.толгой</i> .....	57
График 35. Тариалсан талбай, <i>мянган га</i> .....	58
График 36. Ургац хураалт, <i>мянган тонн</i> .....	58
График 37. Экспорт, импортод ХАА-н үйлдвэрлэлд эзлэх хувь .....	59
График 38. ХАА-ын эл салбарын экспорт, импортын хэмжээ, <i>мян.доллар</i> .....	59
График 39. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө .....	60
График 40. Төрөөс " Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө .....	60
График 41. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө	61
График 42. Шууд үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө .....	62
График 43. Нэг өрхийн хэрэглэж буй ахуйн зориулалттай савны тоо.....	62
График 44. Дам үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө .....	63
График 45. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө	63
График 46. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө .....	64
График 47. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө ..	64
График 48. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө .....	65
График 49. “Ноолуур” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө .....	65
График 50. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө .....	66
График 51. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө .....	66
График 52. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө .....	67
График 53. Сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ болон GAP шинжилгээ.....	69
График 54. Сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ болон GAP шинжилгээ, <i>хөтөлбөр тус бүрээр</i> .....	70
График 55. Сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ болон GAP шинжилгээ, <i>дэд үзүүлэлтээр</i> .....	70
График 56. Бодлого, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн үнэлгээний нэгтгэл .....	71
График 57. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	72
График 58. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	74
График 59. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>дэд үзүүлэлтүүдээр</i> .....	78
График 60. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>үйлчилгээний чанартай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд</i> .....	78



График 84. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн хувьд</i> .....	90
График 85. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд</i> .....	90
График 86. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд</i> .....	91
График 87. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>дэд үзүүлэлтүүдээр</i> .....	91
График 88. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>үйлчилгээний чанартай холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд</i> .....	92
График 89. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд</i> .....	92
График 90. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд</i> .....	92
График 91. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд</i> .....	93
График 92. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд</i> .....	93
График 93. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, <i>ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд</i> .....	94
Зураг 1. Судалгааны хамрах хүрээ, газар нутгийн байршлаар .....	15
Зураг 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд.....	15
Зураг 3. Сэтгэл ханамжийн хэмжүүр.....	17
Зураг 4. Судалгааны төрөл .....	18
Зураг 5. Судалгааны зохион байгуулалт .....	19
Зураг 6. Судалгааны мэдээлэл боловсруулалтад ашиглах программ хангамжийн товч танилцуулга .....	19
Зураг 7. Хяналтын үе шатууд .....	20
Зураг 8. Сэтгэл ханамжийг тодорхойлсон үндсэн үзүүлэлтүүд .....	69

**ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Шигтгээ 1. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл.....	41
Шигтгээ 2. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл.....	42
Шигтгээ 3. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл.....	72
Шигтгээ 4. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл.....	73
Шигтгээ 5. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл.....	74



**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ  
АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү бүлэгт бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээний зорилго, зорилт, хамрах хүрээ, арга зүй, аргачлал, судалгааны төрөл, мэдээлэл цуглуулсан арга, ашигласан программ хангамж, уг ажлыг хийхэд учирсан хүндрэл, бэрхшээл болон судалгааны хязгаарлагдмал байдлын талаар орууллаа.

### 1.1. Үр нөлөөний үнэлгээний зорилго, зорилт

“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, ХХААХҮЯ, орон нутгаас иргэдэд үзүүлж буй ажил, үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийг судлан дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулах, цаашлаад судалгааны ажлын үр дүнг ашиглан бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг сайжруулах, боловсронгуй болгох, оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлох нь энэхүү зөвлөх үйлчилгээний үндсэн зорилго байсан.

Бид дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:


- Бодлого, хөтөлбөрийн үр дүн, ач холбогдол, үр ашиг, тогтвортой байдлыг **тодорхойлох;**
- Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт болон үр дүнгээс бий болсон сайн туршлагыг **тодруулах;**
- Бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг **тодорхойлох;**
- Бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй төрийн бодлого, үйл ажиллагаа **үр шим хүртэгчдэд хүрсэн байдлыг үнэлэх зорилгоор сэтгэл ханамжийг тодорхойлох;**
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн боловсруулалтыг **сайжруулах талаар үр шим хүртэгчдээс санал авах;**
- Санал асуулгын үр дүнд үндэслэн төрөөс үзүүлэх **үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санал боловсруулах;**
- Бодлогын баримт бичгийн хэрэгжүүлэгч холбогдох талуудад (Яам, аймгийн ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, Мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага гэх мэт) үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай **зөвлөмж боловсруулах.**

### 1.2. Хамрах хүрээ

Судалгаанд төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримталж буй бодлого, хөтөлбөрийн үр шимийг шууд болон шууд бусаар хүртсэн **1,500** оролцогчийг хамруулсан.

Байршлын хувьд Ховд, Төв, Дорнод аймгийн төв болон тус бүр 2 сум, Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн 2 хороог хамруулсан.

Зураг 1. Судалгааны хамрах хүрээ, газар нутгийн байршлаар



### 1.3. Арга зүй, аргачлал

#### 1.3.1 Судалгааны ерөнхий загвар

Бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг хэмжих уг зөвлөх үйлчилгээний ажилд **үндсэн 4 төрлийн судалгааны ерөнхий загварыг хослуулан** ашигласан.

#### Загвар 1: Шалгуур үзүүлэлтүүд (OECD-DAC)

Үнэлгээг хийхдээ ЭЗХАХБ-аас гаргасан шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан.

Зураг 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



#### Загвар 2: Бодлогын шинжилгээний Тенбергений загвар

Бодлогын шинжилгээг Тенбергений загвараар үнэлэх бөгөөд хөрөнгө оруулалтын болон санхүүжилтийн бодлогуудын зорилго, зорилтууд, хэрэгжүүлсэн арга хэрэгсэл, бодлогыг хэрэгжүүлэхэд тулгарсан хязгаарлалтууд, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан эерэг сөрөг үр дагаврыг шинжилж, зорилтот болон хүрсэн үр дүнг харьцуулан тодорхойлох бөгөөд эдийн

засгийн статистик эконометрик, зах зээлийн шинжилгээний аргуудаас тохирохыг сонгон, SPSS, EVIEWS болон стандарт программ хангамжуудыг ашигласан.

**Загвар 3: “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 8 дугаар хавсралтад тусгагдсан арга зүй**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д бодлогын үр нөлөөг дараах аргачлалын дагуу үнэлэхээр тусгасан байна.

**Хүснэгт 1. Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээ хийх аргачлал**

Эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тодорхойлсон үр нөлөө	
<b>А. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөлөл</b>	
1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр үзүүлсэн зорилтот болон бусад бүлэг	Бодлогыг хэрэгжүүлснээр хууль ёсны эрх ашиг, санхүүгийн боломж, өнөөгийн нөхцөл байдалд нь шууд болон шууд бусаар нөлөөлсөн нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлно. Зорилтот бүлэг гэж бүлэг хувь хүмүүс, нийгмийн бүлэг, хуулийн этгээд (Засгийн газрын болон орон нутгийн удирдлагын байгууллага, түүний ажилчид) зэрэг тухайн бодлогыг хэрэгжүүлснээр эерэг болон сөрөг нөлөөнд өртсөн бүлгийг хэлнэ.
2. Эдийн засгийн хөгжил	1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлтэд үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох
	2. Захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг тооцоолох:
	2.1. захиргааны үйл ажиллагааны нөлөө хэвээр үлдсэн бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашиг, хариуцлагыг хөндөөгүй гэдгийг тодорхойлон бичих;
	2.2. захиргааны үйл ажиллагааны нөлөө буурч байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс үр шим хүртэж байгаа нийгмийн бүлэг, байгууллага, аж ахуй, салбарыг тодорхойлон бичих;
3. Бусад мэдээлэл	2.3. захиргааны үйл ажиллагааны нөлөө нэмэгдэж байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь нийгмийн ямар бүлэг, байгууллага, аж ахуй, салбарт үзүүлж байгаа ямар гол өөрчлөлтүүд бий болж байгааг тодорхойлон бичих.
	Энэхүү үр нөлөөний үнэлгээний "А"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй эдийн засгийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийн талаар энд бичиж болно.
<b>Б. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл</b>	
1. Хэрэв тухайн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн бол тухайн бүлэгт үзүүлсэн үр нөлөөг тодорхойлно. Үр нөлөөг тодорхойлохдоо тухайн бүлэгт үзүүлсэн нөлөөллийн хэмжээ, нөлөөлсөн магадлал, үр дүнгийн талаар байна. Тухайлбал, орон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газар, жижиг, дунд, том бизнес эрхлэгчид, импортлогчид, экспортлогчид, дотоодын зах зээлд бүтээгдэхүүн ханган нийлүүлэгчид, хэрэглэгчид, газар зүйн бүсүүд, нийгмийн бүлгүүд байна.	
Нийгэмд үзүүлсэн нөлөөлөл нь түр зуурын байх, эсхүл урт хугацааны байх гэдгийг тодорхойлно.	
2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр ямар нөлөө үзүүлэхийг дараах байдлаар тодорхойлсон байна:	
2.1. хүмүүсийн амьдралын хэв маягт үзүүлсэн нөлөөний талаар;	
2.2. хүмүүсийн соёлд ямар нөлөө үзүүлсэн (хамтын итгэл, зан үйл, үнэт зүйл, соёл гэх мэт);	
2.3. хүмүүсийн амьдардаг суурин болон нийгмийн бүлэгт ямар нөлөө үзүүлсэн (уялдаа, тогтвортой байдал, шинж чанар, үйлчилгээ, байгууламж);	

Эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тодорхойлсон үр нөлөө	
2.4. хүрээлэн буй орчинд ямар нөлөө үзүүлсэн (хүмүүсийн хэрэглэдэг ус, амьсгалдаг агаарын чанар, хүнсний бүтээгдэхүүний чанар, олдоц, аюул, эрсдэлийн түвшин, тоос, дуу чимээний хэмжээ, ариун цэврийн байгууламжийн хангамж, байгууламжийн аюулгүй байдал, нөөцөөс хүртэх боломж, нөөцөд хяналт тавих боломж).	
3. Бусад мэдээлэл	Энэхүү нөлөөллийн үнэлгээний "Б"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийн талаар энд бичиж болно.
В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө	
1. Бодлогыг хэрэгжүүлэх явцад бий болсон хууль, эрх зүйн шинэчлэл	Тухайн бодлогыг хэрэгжүүлэх явцад өөрчлөлт, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулсан, батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журмуудыг жагсаан бичнэ.
Г. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлсэн нөлөө	
1.Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлсэн	1. Бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэв төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд өөрчлөлт оруулсан бол энэ хэсэгт өөрчлөлтүүдийг оруулна. (шинээр бий болсон бүтэц, өнөөгийн институцийг татан буулгасан, эсхүл бүтцийг өөрчилсөн байгуулах)
2. Хүний нөөцөд	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхад гарсан бол өөрчлөлтийг бичнэ.

#### Загвар 4: Сэтгэл ханамж болон ач холбогдлын түвшнийг тодорхойлох


##### Сэтгэл ханамж

Иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг (satisfaction) тодорхойлж, сэтгэл ханамжийн индексийг тодорхойлно. Ингэхдээ үнэлгээ хийлгэж буй асуулт бүрийг 1-5 оноогоор үнэлэх бөгөөд “1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн, 9-мэдэхгүй, хариулах боломжгүй” гэсэн сонголтууд байна. Асуултын үнэлгээг асуулт тус бүрийн дундаж утгаар тодорхойлох ба энэ нь 1-5 хүртэлх оноо байна.

Сэтгэл ханамжийн үнэлгээг олон улсын хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хэмжих гол үзүүлэлт болох СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ИНДЕКС - ээр хэмжиж үр дүнг гаргадаг.

Энэхүү шинжилгээнд тодорхой шатлал бүхий хэмжүүрийг ашигладаг бөгөөд анх Ринсис Лайкерт 1932 онд боловсруулан гаргасан ба өнөөг хүртэл олон улсад өргөн ашиглагдаж байна.

##### Зураг 3. Сэтгэл ханамжийн хэмжүүр



**Ач холбогдол**

Ач холбогдлын түвшнийг хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хэмжих гол үзүүлэлт болох СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ИНДЕКС – ээр харьцуулан тооцдог.

Энэ нь тухайн иргэдэд өгч буй бүтээгдэхүүн үйлчилгээний нэгж үзүүлэлт бүрийг хэрэглэгчийн хүлээлт болон ач холбогдолтой харьцуулан сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатай үзүүлэлтүүдийг **нарийн эрэмбэлэх боломжийг** бий болгоно.

**GAP шинжилгээ**

GAP Шинжилгээ нь сэтгэл ханамжаас ач холбогдлыг хасах байдлаар тооцдог ба гол үр дүн нь тухайн сэтгэл ханамж, дэд болон нэгж үзүүлэлт бүрийн хэрэглэгчийн хүлээлт, ач холбогдлоос хэрхэн зөрж байгааг тодорхойлох юм.

$$GAP = \text{Сэтгэл ханамж} - \text{Ач холбогдол}$$

GAP = сөрөг утга, Хэрэглэгчийн хүлээлтэд хүрч чадахгүй байна.


GAP = 0, Хэрэглэгчийн хүлээлтэд бүрэн нийцэж байна.

GAP = эерэг утга, Хэрэглэгчийн хүлээлтээс давсан бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож байна.

**1.4. Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулсан арга**

Үнэн бодитой тэнцвэртэй, шинжлэх ухааны үндэслэл, баталгаатай мэдээлэл авах зорилгоор судалгаанд анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг ашигласан.

**Зураг 4. Судалгааны төрөл**



Судалгаанд хамрагдах иргэдийн тоог статистик аргачлалын дагуу сонгосон бөгөөд тоон болон чанарын судалгааны хувьд дараах байдлаар түүврийн хэмжээг тодорхойлсон.

**Хүснэгт 2. Судалгааны төрөл**

№	Судалгааны төрөл	Түүврийн нэгж	Хамрах хүрээ	Түүврийн хэмжээ
---	------------------	---------------	--------------	-----------------

1	Тоон судалгаа	<ul style="list-style-type: none"> <li>• Иргэн</li> </ul>	Улаанбаатар хот, 3 аймаг	n=1,500 үр шим хүртэгч
2	Ганцаарчилсан ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>• Бодлого, хөтөлбөрийн үр шим хүртэгчид</li> <li>• Бодлого боловсруулагчид</li> <li>• Эрдэмтэн судлаачид</li> </ul>	Улаанбаатар хот, 3 аймаг	n=52

1.5. Судалгааны зохион байгуулалт

Судалгааны үр дүнг бодитой бөгөөд үнэн зөв, чанартай хийж гүйцэтгэх зорилгоор дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн.

Зураг 5. Судалгааны зохион байгуулалт



1.6. Тайлан боловсруулахад ашигласан программ хангамж

Бид ашиглаж буй аргаас хамааруулан дараах програм хангамжийг ашигласан

Зураг 6. Судалгааны мэдээлэл боловсруулалтад ашиглах программ хангамжийн товч танилцуулга



1.7. Судалгааны хяналтын үе шатууд

Бид судалгааны үе шат бүрд дараах хяналтуудыг хийсэн.

## Зураг 7. Хяналтын үе шатууд

1. СУРГАЛТЫН ХЯНАЛТ	2. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ	3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ДАРААХ ХЯНАЛТ	4. МЭДЭЭЛЭЛ ШИВЭЛТИЙН ХЯНАЛТ
<p>Судлаачдыг сургалтад хамруулж, шалгалт авч сонгон шалгаруулдаг.</p> <p><b>СУРГАЛТЫН ҮЕ ШАТ</b></p> <p>Сургалтын нээлт</p> <p>Судалгааны тухай ойлголт, арга зүй</p> <p>Асуулгын хуудасны зааварчилгаа</p> <p>Программ дээр ажиллах зааварчилгаа</p> <p>Таблеттай ажиллах зааварчилгаа</p> <p>Дадлага ажил</p> <p>Аюулгүй ажиллагааны зааварчилгаа</p> <p>Мэдээлэл цуглуулахад анхаарах асуудал</p>	<p>Дуу хураагуур, утас, GPS байршил тогтоогч ашигладаг.</p> <p><b>АРГА ЗҮЙ</b></p> <p>Өдөр бүр тухайн судалгааны хянагч бичлэгийг тулган сонсож хяналт тавих;</p> <p>Тухай бүр ирсэн датаг хөрвүүлэн гарсан алдааг шалгаж анхааруулах;</p> <p>Судалгааны явцад зорилтот бүлгийн оролцогч судалгаанд хамрагдсан эсэхэд байнга хяналт тавих;</p>	<p>Судалгаанд оролцогчидтой утсаар холбогдон зарим асуултыг шалган асуудаг.</p> <p><b>АРГА ЗҮЙ</b></p> <p>Цуглуулсан мэдээлэлд логик алдааг шалгах</p> <p>(Eyeballing) хэт ялгаатай утгыг хянаж, засварлах</p>	<p>Шивэлтийн алдааг алдааны программ болон (давхар шивэлт) Double entry хийж шалгадаг.</p> <p><b>АРГА ЗҮЙ</b></p> <p>Давхар шивэлт /Double entry/ тухайн судалгаанаас хамааран тодорхой хувьд давхар шивэлт хийгдэнэ;</p> <p>Шивэлтийн оператор бүрийн нийт шивсэн асуулгаас түүвэрчлэн хяналт хийх;</p> <p>Алдааны протокол /Run batch entry/ уншуулж алдааг хянаж, алдаа зассан эсэхэд хяналт хийх;</p>

## 1.8. Үр нөлөөний үнэлгээг хийхэд учирсан хүндрэл, бэрхшээл

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэж байх хугацаанд дараах хүндрэл, бэрхшээлүүд учирсан бөгөөд захиалагч талын дэмжлэг болон “Эс Ай Си Эй” ХХК-ийн удирдах багийн оновчтой зохион байгуулалтын үр дүнд амжилттай даван туулж чадсан.

- Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээний ажлын хүрээнд судалгаа хийгдэх зорилтот бүс нутаг болох Дорнод аймгийн Баянтүмэн сумын 2 дугаар багийн нутаг “Хулстайн булаг” гэдэг газарт малын гоц халдварт үхрийн арьс төвруутах өвчин оношлогдсонтой холбоотой хорио цээрийн дэглэм тогтоох, тэмцэх арга хэмжээ авч бүх сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, тасгийн малын эмч нар тандалт, шинжилгээний дээж цуглуулах багт ажиллаж байсан. Энэхүү нөхцөл байдал нь оролцогч талуудтай ярилцлага хийх, судалгаа авахад хүндрэл, бэрхшээл учруулж төвлөсөн хугацаанд тухайн бүс нутагт ажиллах боломжийг хязгаарлаж байлаа.
- Үнэлгээ хийж буй төрөөс баримтлах 2 бодлого, 5 үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн үр шим хүртэгчдийг олж судалгаа авах нь судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг удаашруулах нэг шалтгаан болж байсан.

## 1.9. Судалгааны хязгаарлагдмал байдал

Судалгаанд төрөөс баримтлах 2 бодлого, 5 үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийг хамруулахдаа тэдгээрийн онцлогт тохирсон асуулгын хуудсыг зохиосон тул оролцогчдын төрөл бүрээр харьцуулан ач холбогдлыг тооцох, дүгнэлт хийх боломж хязгаарлагдмал байлаа.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНД  
ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Энэхүү бүлэгт судалгаанд хамрагдсан үр шим хүртэгчдийн хүн ам зүйн ерөнхий мэдээлэл болон бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой төрийн байгууллагаас үйлчилгээ авахад учирсан хүндрэл, бэрхшээл, мэдээ, мэдээллийг авдаг эх сурвалж, түүний хүртээмжтэй байдлын талаар орууллаа.

**2.1. Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл**

Судалгаанд нийт 1,500 үр шим хүртэгч хамрагдсан бөгөөд үүний 21.5 хувь нь Ховд, 19.8 хувь нь Төв, 22.8 хувь нь Дорнод аймгийн төлөөлөл байсан. Харин үлдсэн 35.9 хувь нь Улаанбаатар хотоос хамрагджээ.

Судалгаанд оролцсон үр шим хүртэгчдийн 47.5 хувь эрэгтэй, 52.5 хувь нь эмэгтэй оролцогчид байсан.

Судалгаанд оролцогчдыг насны хувьд ангилан авч үзвэл 11.1 хувь нь 20-29, 24.4 хувь нь 30-39, 20.1 хувь нь 40-49, 19.5 хувь нь 50-59, 24.9 хувь нь 60-аас дээш насныхан байсан. Энэхүү үр дүн нь судалгааны баг түүврийн хуваарилалтыг жигд тархаасан ба эх олонлогийг бүрэн төлөөлөх боломжтойг илэрхийлж байна.

Боловсролын түвшний хувьд хамгийн их хувь нь буюу 41.0 хувь нь бүрэн дунд боловсролтой, 27.2 хувь нь дипломын болон бакалаврын боловсролтой байлаа.

Өрхийн орлогын хувьд судалгаанд оролцогчдын 35.7 хувь нь 500,000 төгрөг хүртэлх, 29.5 хувь нь 500,001-1,000,000 төгрөг хүртэлх, 18.3 хувь нь 1,000,001-1,500,000 төгрөг хүртэлх, 6.9 хувь нь 1,500,001-2,000,000 төгрөг хүртэлх, 9.6 хувь нь 2,000,001-ээс дээш төгрөгийн орлогыг сард олдог байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд 13.0 хувь нь төрийн байгууллагад ажилладаг, 15.7 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 18.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байсан бол 33.5 хувь нь малчин байв.

**Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл**

№	Үзүүлэлт	Давтамж	Хувь	
1	Судалгаанд оролцогчийн амьдарч буй байршил	Ховд аймаг	323	21.5%
		Төв аймаг	297	19.8%
		Дорнод аймаг	342	22.8%
		Улаанбаатар хот	538	35.9%
2	Судалгаанд оролцогчийн нас	20-29	167	11.1%
		30-39	366	24.4%
		40-49	301	20.1%
		50-59	292	19.5%
		60-аас дээш	374	24.9%
3	Боловсролын түвшин	Боловсролгүй	14	0.9%
		Бага боловсрол (1-5 анги)	37	2.5%
		Бүрэн бус дунд боловсрол (6-9 анги)	262	17.5%
		Бүрэн дунд боловсрол (10-12 анги)	615	41.0%
		МСҮТ болон тусгай мэргэжлийн дунд	93	6.2%

№	Үзүүлэлт	Давтамж	Хувь	
	Дипломын болон бакалавр	408	27.2%	
	Магистр болон түүнээс дээш	71	4.7%	
4	Өрхийн сарын дундаж орлого	500,000 төгрөг хүртэл	536	35.7%
		500,000-1,000,000 төгрөг	443	29.5%
		1,000,001-1,500,000 төгрөг	274	18.3%
		1,500,001-2,000,000 төгрөг	103	6.9%
		2,000,001-ээс дээш	144	9.6%
5	Хүйс	Эрэгтэй	712	47.5%
		Эмэгтэй	788	52.5%
6	Хөдөлмөр эрхлэлтийн байдал	Төсвийн байгууллага /Төр/	195	13.0%
		Хувийн байгууллага	235	15.7%
		ТББ/Олон улсын байгууллага	7	0.5%
		Нөхөрлөл/Хоршоо	7	0.5%
		Хувиараа хөдөлмөр эрхлэгч	270	18.0%
		Тэтгэвэр, групп	200	13.3%
		Малчин	502	33.5%
		Оюутан	22	1.5%
		Ажилгүй	62	4.1%
<b>Нийт</b>		<b>1,500</b>	<b>100.0%</b>	

Судалгааны түүврийн хуваарилалтыг хийхдээ хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжсэн 5 үндэсний хөтөлбөрт тэнцүү тоогоор хуваарилсан ба 2 бодлогыг хөтөлбөр тус бүрд оруулсан болно. Хөтөлбөрүүдийн үр шим хүртэгчдийг дараах байдлаар тодорхойлсон.

#### Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын төрөл, хөтөлбөр тус бүрээр

№	Хөтөлбөр	Судалгааны оролцогч тал
1	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн тухайд дараах төлөөллүүд судалгаанд хамрагдсан.	<ol style="list-style-type: none"> <li>Энэ салбарт үйл ажиллагаа эрхлэгч "ХХК"</li> <li>Энэ салбарт үйл ажиллагаа эрхлэгч "Хоршоо"</li> <li>Энэ салбарт үйл ажиллагаа эрхлэгч "Иргэн"</li> <li>Хэрэглэгч/иргэн</li> <li>Малчин болон мал бүхий иргэн</li> <li>Худалдаа, үйлчилгээний байгууллагын төлөөлөл /нийтийн хоолны газар, ЕБС, цэцэрлэг, ЭМБ гм/</li> </ol>
2	“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн тухайд дараах төлөөллүүд судалгаанд хамрагдсан.	<ol style="list-style-type: none"> <li>Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч</li> <li>Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч</li> <li>Арьс, ширэн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч</li> <li>Өрхийн түвшинд үйлдвэрлэл эрхлэгч</li> <li>Хоршоо</li> <li>Иргэн</li> <li>Малчин</li> </ol>
3	“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн тухайд дараах төлөөллүүд судалгаанд хамрагдсан.	<ol style="list-style-type: none"> <li>Фермерийн үйл ажиллагаа эрхлэгч/Эрчимжсэн аж ахуй эрхлэгч</li> <li>Мах боловсруулах үйлдвэрүүд</li> <li>Малчин, мал бүхий иргэн</li> <li>Малын эмч</li> <li>Хэрэглэгч/иргэн</li> <li>Нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа эрхлэгч</li> </ol>

№	Хөтөлбөр	Судалгааны оролцогч тал
4	“Ноолуур” үндэсний хөтөлбөрийн тухайд дараах төлөөллүүд судалгаанд хамрагдсан.	1. Энэ салбарт үйлдвэрлэл эрхлэгч 2. Төслийн үр шим хүртэгч иргэн /малчин, мал бүхий иргэн гм/
5	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн тухайд дараах төлөөллүүд судалгаанд хамрагдсан.	1. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 2. Фермерийн үйл ажиллагаа эрхлэгч/Эрчимжсэн аж ахуй эрхлэгч 3. Импортын тэжээл болон бусад бүтээгдэхүүн нийлүүлэгч 4. Хэрэглэгч/иргэн 5. Нийтийн хоолны салбарын төлөөлөл

**2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөртэй холбоотой төрийн байгууллагаас үйлчилгээ авахад учирсан хүндрэл, бэрхшээл**

Судалгаанд хамрагдсан үр шим хүртэгчдээс бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой төрийн байгууллагаас үйлчилгээ авахад хүндрэл, бэрхшээл учирч байсан эсэхийг тодруулахад 14.7 хувь нь тийм гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл 10 оролцогч тутмын 1 оролцогчид ямар нэгэн бэрхшээл тулгарч байжээ.

Хөтөлбөр тус бүрээр ялган харвал “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдэд бусад хөтөлбөрийн үр шим хүртэгчидтэй харьцуулахад илүү их хүндрэл, бэрхшээл тулгарсан байна. Харин “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдэд харьцангуй бага байгааг дараах графикаас харах боломжтой.


**График 1. Үйлчилгээ авахад учирсан хүндрэл, бэрхшээл, n=1,500**



Хүндрэл, бэрхшээл учирсан гэж хариулсан оролцогчдоос чухам ямар төрлийн хүндрэл бэрхшээл учирсан болохыг тодруулахад 63.8 хувь нь хариу өгөх байдал удаашралтай байсан, 37.6 хувь нь зөвлөгөө мэдээлэл авахад хугацаа их зарцуулсан, 34.4


хувь нь хариуцсан мэргэжилтний мэргэжлийн ур чадвар дутмаг байсан, 32.6 хувь нь бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, ойлгомжгүй байсан, 30.8 хувь нь хариуцсан мэргэжилтэн ажлын байран дээрээ байгаагүй гэх зэрэг шалтгааныг нэрлэсэн байна.

**График 2. Ямар хүндрэл, бэрхшээл учирсан талаарх сэтгэгдэл, n=221**



Судалгаанд оролцсон нийт үр шим хүртэгчдээс ХХААХҮЯ болон харьяа байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд ямар арга хэмжээг авах нь тохиромжтой болохыг тодруулахад 54.1 хувь нь иргэдийг мэдээ, мэдээллээр сайтар хангах, 46.7 хувь нь төрийн албаны хүнд суртлыг бууруулах, 45.4 хувь нь төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, 33.3 хувь нь төрийн үйлчилгээг цахимжуулах, 7.7 хувь нь албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, 7.0 хувь нь албан хаагчдын тоог бууруулах хэрэгтэй гэж хариулсан байна. Мөн зарим оролцогчид төрийн байгууллагууд аливаа бодлого, хөтөлбөр, шийдвэрийг иргэдийн бодит амьдралын нөхцөл байдлыг сайтар судалсны үндсэн дээр гаргах хэрэгтэй хэмээн хариулжээ.

График 3. ХХААХҮЯ болон харьяа байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд ямар арга хэмжээг авах нь тохиромжтой гэж үзэж байна вэ?, n=1,500



### 2.3. Мэдээллийн эх сурвалж

Судалгаанд оролцогчдоос ХХААХҮЯ болон харьяа байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг болохыг тодруулахад 70.6 хувь нь телевиз, 43.8 хувь нь сошиал медиа, 25.4 хувь нь интернэт, тухайн байгууллагын веб сайт, 20.1 хувь нь танил хүмүүсээсээ авдаг гэж хариулжээ.

Харин төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх үүрэг бүхий төрийн байгууллагын мэргэжилтнүүдээс мэдээлэл авдаг хэмээн хариулсан хариултын хувь маш бага хувийг эзэлж байгаа нь анхаарал татахуйц үр дүн байлаа. Мөн судалгаанд оролцогчдын 0.9 хувь нь мэдээ, мэдээлэл огт авдаггүй гэсэн байна.

График 4. Мэдээллийн эх сурвалж, n=1,500



Дээрх үр дүнг батлах зорилгоор бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй боловсон хүчин, холбогдох ажилтнууд хэр сайн мэдээлэл өгдөг байсныг тодруулахад 49.4 хувь нь мэдээлэл маш муу өгдөг байсан гэж хариулсан байна.

График 5. Бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй боловсон хүчин, холбогдох ажилтнууд танд хэр сайн мэдээлэл өгдөг байсан бэ?, n=1,500





**ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОДЛОГО,  
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ҮР ДҮН, ҮНЭЛГЭЭ**

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ҮР ДҮН, ҮНЭЛГЭЭ

Энэхүү бүлэгт бодлого, хөтөлбөрүүдэд хийсэн дүн шинжилгээ, ач холбогдол, үр дүн, үр ашиг, тогтвортой байдал ба сайн туршлага, сургамжийн талаар орууллаа.

### 3.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөрүүдэд хийсэн дүн шинжилгээ


Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2015-2019 онд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлд дараах хоёр бодлого, таван хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн.

- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого
  - “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр
  - “Ноолуур” үндэсний хөтөлбөр
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
  - “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр
  - “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр
  - “Эрүүл хүнс - Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр

Дээрх хоёр бодлогын хүрээнд батлагдсан таван үндэсний хөтөлбөрийг аймгууд хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, журамд нийцүүлэн өөрийн онцлогт тохируулан үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах замаар үйл ажиллагаа хэрэгжүүлж, тодорхой хэмжээний үр нөлөөг иргэд, олон нийтэд хүргэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зүгээс төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжих явцад явцын үнэлгээг журамд заасан хугацаанд тухай бүр хийжээ. Эдгээр бодлого, хөтөлбөрийн явцад 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн ХХААХҮЯ-ны ХШҮ-ний дундаж үзүүлэлт 74.1 хувьтай байна.

График 6. Салбарт баримталсан бодлого, хөтөлбөрийн мониторинг үнэлгээний дүн, хувиар



\*Бодлого, хөтөлбөрүүдийн хувьд ХШҮ хийсэн хугацаа харилцан адилгүй байсан тул давтамжаар нь графикт харууллаа.

Бодлогын баримт бичгүүдэд хийгдсэн SMART шинжилгээ - Зорилго нь нарийвчлан тодорхойлогдсон, зорилтууд нь зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн, төсөл хэрэгжүүлэгчийн цаашид юу хийвэл зохих тухай бодол санаа буюу төлөвлөсөн зүйлүүдээ нэгтгэн дүгнэхэд нэн тэргүүнд ашиглагддаг шинжилгээ юм.

#### Хүснэгт 5. Бодлогын баримт бичгүүдийн дүн шинжилгээ

Бодлого, хөтөлбөрийн нэр	Товч мэдээлэл	S	M	A	R	T
		Зорилго нь тодорхой эсэх	Хэмжиж болохуйц эсэх /тоо хувиар илэрхийлэх/	Хүрэх боломжтой байсан эсэх	Бодитой эсэх	Товлосон хугацаатай эсэх
Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулах хүрээнд 6 зорилт 70 үйл ажиллагааны хүрээнд батлагдсан.	Бодлогын зорилго <b>тодорхой биш</b> байсан. Бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулна гэж байгаа нь хэт ерөнхий байна.	Индикаторууд нь үндсэн зорилготой уялдахгүй байна. Тодруулбал индикаторуудад бүтээмжийг хэмжих /хөтөлмөрийн бүтээмж, капиталын бүтээмж гм/, түүнийг сайжирсан гэж үзэх индикатор байхгүй байна.	Бодлогыг хэрэгжүүлэх хүний нөөц, түүний чадавх, шаардагдах төсөв зэрэг суурь нөхцөлүүдийг хэрхэн тогтвортой байлгахыг шийдвэрлээгүй, уялдаа холбоо муутай байсан.	Зорилго болон шалгуур үзүүлэлтүд хоорондоо уялдаа, холбоо муутай, нөөцийг тооцоолоогүй тул бодитой биш байсан.	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг ямар хугацаанд хэрхэн, яаж хийх нь тодорхой биш байна.
Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого нь дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын	Бодлогын зорилго <b>тодорхой</b> байсан.	Бодлогын үр дүнг хэмжих индикатор байхгүй байсан.	Бодлогыг хэрэгжүүлэх хүний нөөц, түүний чадавх, шаардагдах төсөв зэрэг суурь нөхцөлүүдийг хэрхэн тогтвортой байлгахыг	Шалгуур үзүүлэлт, бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, нөөцийг тооцоолоогүй тул бодитой биш байсан.	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг ямар хугацаанд хэрхэн, яаж хийх нь тодорхой биш байна.

Бодлого, хөтөлбөрийн нэр	Товч мэдээлэл	S	M	A	R	T
		Зорилго нь тодорхой эсэх	Хэмжиж болохуйц эсэх /тоо хувиар илэрхийлэх/	Хүрэх боломжтой байсан эсэх	Бодитой эсэх	Товлосон хугацаатай эсэх
	тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгын хүрээнд 8 зорилт 44 үйл ажиллагааны хүрээнд батлагдсан. Шалгуур үзүүлэлт байхгүй.			шийдвэрлээгүй, уялдаа холбоо муутай байсан.		
“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр	2017 онд Сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулах зорилгын хүрээнд 3 зорилт 29 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлагдсан.	Хөтөлбөрийн зорилго <b>тодорхой</b> байсан.	Хөтөлбөрийн үр дүнг хэмжих 4 индикатор хэмжиж болохуйц байсан.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөц, түүний чадавх, шаардагдах төсөв зэрэг суурь нөхцөлүүдийг хэрхэн тогтвортой байлгахыг шийдвэрлээгүй, уялдаа холбоо муутай байсан. Харин үндсэн зорилго, зорилтууд бодитой байсан.	Нөөцийг тооцоолоогүй тул бодитой биш байсан.	Хөтөлбөрийг бүхэлд нь хэрэгжүүлэх хугацаа тодорхой байсан.
“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр	2018 онд Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар,	Хөтөлбөрийн зорилго <b>тодорхой</b> байсан.	Хөтөлбөрийн үр дүнг хэмжих 8 индикатор хэмжиж болохуйц байсан.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөц, түүний чадавх, шаардагдах төсөв зэрэг суурь	Нөөцийг тооцоолоогүй тул бодитой биш байсан.	Хөтөлбөрийг бүхэлд нь хэрэгжүүлэх хугацаа тодорхой байсан. Мөн хэрэгжүүлэх үйл

Бодлого, хөтөлбөрийн нэр	Товч мэдээлэл	S	M	A	R	T
		Зорилго нь тодорхой эсэх	Хэмжиж болохуйц эсэх /тоо хувиар илэрхийлэх/	Хүрэх боломжтой байсан эсэх	Бодитой эсэх	Товлосон хугацаатай эсэх
	стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 5 зорилт дэвшүүлж, 43 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлагдсан.			нөхцөлүүдийг хэрхэн тогтвортой байлгахыг шийдвэрлээгүй, уялдаа холбоо муутай байсан. Мөн 21 аймагт 100 үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн хөтөлбөрийн зорилго, зорилт бодитой биш байна.		ажиллагааны хугацаа нь үе шат бүрээр тодорхойлогдсон нь онцлог байлаа.
“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2018 онд мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж,	Хөтөлбөрийн зорилго <b>тодорхой</b> байсан.	Хөтөлбөрийн үр дүнг хэмжих 9 индикаторын 7 нь хэмжиж болохуйц байсан. Үлдсэн 2 индикаторыг хэрхэн хэмжих нь тодорхой биш байна.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөц, түүний чадавх, шаардагдах төсөв зэрэг суурь нөхцөлүүдийг хэрхэн тогтвортой байлгахыг шийдвэрлээгүй, уялдаа холбоо муутай байсан.	Нөөцийг тооцоолоогүй тул бодитой биш байсан. Мөн шалгуур үзүүлэлтүүдийн зарим нь тодорхой биш байсан.	Хөтөлбөрийг бүхэлд нь хэрэгжүүлэх хугацаа тодорхой байсан.


Бодлого, хөтөлбөрийн нэр	Товч мэдээлэл	S	M	A	R	T
		Зорилго нь тодорхой эсэх	Хэмжиж болохуйц эсэх /тоо хувиар илэрхийлэх/	Хүрэх боломжтой байсан эсэх	Бодитой эсэх	Товлосон хугацаатай эсэх
	мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 6 зорилт дэвшүүлж, 28 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлагдсан.					
“Ноолуур” хөтөлбөр	2018 онд Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 60 хувьд хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгын хүрээнд 5 зорилт дэвшүүлж, 31 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлагдсан.	Хөтөлбөрийн зорилго <b>тодорхой</b> байсан.	Хөтөлбөрийн үр дүнг хэмжих 4 индикатор хэмжиж болохуйц байсан.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөц, түүний чадавх, шаардагдах төсөв зэрэг суурь нөхцөлүүдийг хэрхэн тогтвортой байлгахыг шийдвэрлээгүй, уялдаа холбоо муутай байсан.	Нөөцийг тооцоолоогүй тул бодитой биш байсан.	Хөтөлбөрийг бүхэлд нь хэрэгжүүлэх хугацаа тодорхой байсан. Мөн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хугацаа нь үе шат бүрээр тодорхойлогдсон нь онцлог байлаа.
“Эрүүл хүнс- Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр	2019 онд хүнсний аюулгүй байдлыг хангаж, Монгол хүн эрүүл байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд 5 зорилт дэвшүүлж, 53 үйл	Хөтөлбөрийн зорилго <b>тодорхой</b> байсан.	Хөтөлбөрийн үр дүнг хэмжих 13 индикаторын 7 нь хэмжиж болохуйц байсан. Үлдсэн 3 индикаторыг	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөц, түүний чадавх, шаардагдах төсөв зэрэг суурь	Нөөцийг тооцоолоогүй тул бодитой биш байсан. Мөн шалгуур үзүүлэлтүүдийн зарим нь	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа албан ёсны баримт бичигт тусгагдсанаар

Бодлого, хөтөлбөрийн нэр	Товч мэдээлэл	S	M	A	R	T
		Зорилго нь тодорхой эсэх	Хэмжиж болохуйц эсэх /тоо хувиар илэрхийлэх/	Хүрэх боломжтой байсан эсэх	Бодитой эсэх	Товлосон хугацаатай эсэх
	ажиллагааг хэрэгжүүлэхээр батлагдсан.		хэрхэн хэмжих нь тодорхой биш байна.	нөхцөлүүдийг хэрхэн тогтвортой байлгахыг шийдвэрлээгүй, уялдаа холбоо муутай байсан.	тодорхой биш байсан.	тодорхой биш байсан.




Судалгаанд хамрагдсан бодлого, хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн иргэд, үйлдвэрлэл эрхлэгчдийн 87.0 хувь нь төрөөс “Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” ач холбогдолтой байсан гэж үзжээ. Тэднийг хөтөлбөр тус бүрээр нь нарийвчлан харвал “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн хувьд дээрх бодлого нь ач холбогдол хамгийн өндөртэй байсан бол “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн хувьд ач холбогдол хамгийн багатай байсан хэмээн үзсэн байна.

**График 8. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэр ач холбогдолтой байсан бэ?**




Судалгаанд хамрагдсан бодлого хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн иргэд, үйлдвэрлэл эрхлэгчдийн 67.5 хувь нь төрөөс “Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” ач холбогдолтой байсан гэж үзжээ. Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөр тус бүрээр нь нарийвчлан харвал “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрүүдийн үр нөлөө хүртэгчдийн хувьд ач холбогдол хамгийн багатай байжээ.

**График 9. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр ач холбогдолтой байсан бэ?**



Төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 95.0 хувь нь тус хөтөлбөрийг ач холбогдолтой байсан хэмээн үзжээ. Харин “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 75.0 хувь нь тус хөтөлбөрийг ач холбогдолтой байсан хэмээн үзэж байна. Бусад гурван үндэсний хөтөлбөрийн хувьд үр нөлөө хүртэгчдийн 89.4-85.4 хувь нь ач холбогдолтой байсан гэж үзжээ.

График 10. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр ач холбогдолтой байсан бэ?



### 3.3. Бодлого, хөтөлбөрүүдийн үр дүн

Судалгаанд хамрагдсан бодлого, хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 81.8 хувь төрөөс “Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” үр дүнтэй байсан гэж үзэж байгаа бол 65.0 хувь нь төрөөс “Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого үр дүнтэй байсан хэмээн үзсэн байна.

Хөтөлбөрүүдийн хувьд судалгаанд хамрагдсан иргэдийн 91.0 хувь нь “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр дүнтэй байсан хэмээн үзэж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Харин тэдний 27.5 хувь нь “Ноолуур” үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй байсан гэж үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хувьд малчид гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг цаг тухайд нь хийлгэж байгаагаас гадна сум, багийн малын эмч нар дуудлагаар ирж малын үзлэг хийдэг нь хамгийн их дурдагдсан бөгөөд малын тарилга хийлгэсэн гэрчилгээнд үндэслэн малчид малын түүхий эдээ борлуулж байна. Үйлдвэрлэл эрхлэгчид болон хэрэглэгчдийн хувьд малын өвчингүйг баталгаажуулж малын түүхий эдийг үйлдвэрлэл болон хүнсэндээ хэрэглэж байна. Мөн тус салбарын албан хаагчдын хувьд мал эмнэлгийн цахим системийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байсан бөгөөд энэхүү цахим систем болон малын гаралтай түүхий эдийг хэрхэн шалгаж авахыг иргэдэд таниулж сурталчлах хэрэгтэйг анхааруулж байсан.


Ноолуур үндэсний хөтөлбөрийн хувьд малчид ямааны ноолуураа зарахаас гадна ноолуурын урамшуулал авсан нь хамгийн том үр дүн хэмээн харж байгаа ч мэргэжилтнүүдийн хувьд ноолуурын урамшууллаас болж малчид цөм сүрэг дэх ямааны тоо толгойг нэмэгдүүлж маллах хандлагатай байгаа тул урт хугацааны байгаль орчны тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай хэмээн харж байна.

График 11. Бодлого, хөтөлбөрүүдийн үр дүн



Судалгааны үр дүнг ХХААХҮЯ-ны ХШҮ-ний дундаж үзүүлэлттэй харьцуулахад “Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, “Ноолуур” үндэсний хөтөлбөр, “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үнэлгээ нэлээд зөрүүтэй байсан. Судалгааны багийн зүгээс үүний шалтгааныг зөв эсвэл буруу үнэлсэн гэхээс илүү хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл түгээлт, олон нийтийн талаарх ойлголттой холбоотой хэмээн таамаглаж байна.


График 12. Үр нөлөөний үнэлгээг ХХААХҮЯ-ны ХШҮ-ний дүнтэй харьцуулсан үр дүн



\*Бодлого, хөтөлбөрүүдийн хувьд ХШҮ хийсэн хугацаа харилцан адилгүй байсан тул давтамжаар нь графикт харууллаа.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 81.8 хувь нь төрөөс “Хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” үр дүнтэй байсан хэмээн үзжээ. Тэднийг хөтөлбөр тус бүрээр нарийвчлан харвал “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн хамгийн их хувь нь тус бодлогыг үр дүнтэй хэрэгжсэн хэмээн үнэлсэн байна.

**График 13. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэр үр дүнтэй байсан бэ?**




Судалгаанд хамрагдсан иргэдийн 77.5 хувь нь төрөөс “Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” үр дүнтэй байсан хэмээн үзэж байна. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн тал хувь нь буюу 47.4 хувь нь уг бодлогыг огт амжилтгүй хэрэгжсэн гэж үзсэн нь анхаарал татах үр дүн байлаа.

**График 14. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр үр дүнтэй байсан бэ?**



Хөтөлбөрүүдийн үр дүнгийн үнэлгээг дараах графикт харууллаа.

График 15. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр үр дүнтэй байсан бэ?



“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн 86.4 хувь нь тус хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэж байна. Шууд байдлаар үр шим хүрсэн иргэдийн хувьд мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэхээс гадна үйлдвэржилтийн бүтээмж нэмэгдэх арга хэмжээг авсан бол дам байдлаар үр нөлөө хүртсэн иргэдийн хувьд хэрэглэж буй хоол хүнснийхээ чанар, шим тэжээлд илүүтэй анхаарах болсон байна. Хөтөлбөрийн үр нөлөөг дам байдлаар хүрсэн иргэдийн хувьд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Өрхийн хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүний сонгохдоо чанарт анхаардаг болсон
- Хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг бий болгосон
- Хүнсний бүтээгдэхүүний шошго, хоолны цэсэд тухайн бүтээгдэхүүний эзлэх шим тэжээлийг анхаарч хардаг болсон
- Органик хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсэн
- Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамлын тариалалт нэмэгдсэн
- Бүтээгдэхүүний гарал үүсэл тодорхой байдаг болсон

Хөтөлбөрийн үр шимийг шууд хүртсэн иргэд, аж ахуй нэгжийн хувьд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мэдлэг мэдээлэл нэмэгдүүлэх, чадваржуулах, мэргэшүүлэх, санал солилцох сургалт семинар, үйл ажиллагаанд хамрагдсан
- Жимс хүнсний ногоо, үр тариа тариалах болон ургалт, хураалтын ажил илүү сайжирсан
- Хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдсан /ЖДҮДС/
- Хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдсан /Орон нутгийн хөгжлийн сан/
- Бүтээн байгуулалт, өргөтгөл хийсэн /Зоорь, агуулах, үйлдвэр гм/
- Хүнсний лабораторийн үйл ажиллагаа сайжирсантай холбоотой хоол үйлдвэрлэлийн салбарт илүү эрүүл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарах болсон

- Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт дэмжлэг үзүүлсэн /Нэгдсэн сантай болсон гэх мэт/

### Шигтгээ 1. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл

*Манайх бүтээгдэхүүнээ савлахдаа хүнсний зориулалтын уут ашигладаг, анх бүтээгдэхүүний шошгоо гаргахдаа МХГ –ын зөвлөгөөний дагуу 9 үзүүлэлтийг тусгаж байсан.*

*Дорнод аймгийн Хэрлэн сумын дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр*

*Мэргэжлийн хяналтын газраас ирж хяналт шалгалт хийж саваа хүнсний зориулалтын болгох шаардлагыг тавьдаг. Манай суманд нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг зоогийн газрууд бүгд саваа сольсон.*

*Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч өрх*

“Үйлдвэржилт” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн 80.4 хувь нь тус хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэж байна. Тус хөтөлбөрийн шууд үр нөлөө хүртэгчдийн хувьд ямар нэг зээл тусламжид хамрагдаж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлж, бүтээгдэхүүний стандартжуулсан нь хамгийн гол үр дүн байжээ. Харин дам байдлаар үр нөлөө хүртэгчдийн хувьд орон нутагт нь шинэ бүтээн байгуулалт үйлдвэрлэл нэмэгдсэнээр ажлын байр нэмэгдэх, иргэдийн орлого тодорхой хэмжээгээр өсөхөд нөлөөлсөн хэмээн үзэж байна. Малчдын хувьд худаг баригдсан гэж үзэж байгаа ч зарим орон нутгийн хувьд худаг усны асуудал байсаар байна. Хөтөлбөрийн үр нөлөөг дам байдлаар хүрсэн иргэдийн хувьд дараах өөрчлөлтүүд гарсан хэмээн үзжээ. Үүнд:

- Орон нутагт үйлдвэрлэсэн органик бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсэн
  - Малчид малаа зориулалтын худгийн усаар усалдаг болсон
  - Манай орон нутагт инженерийн худаг баригдсан
  - Шинээр баригдсан бүтээн байгуулалтын нөлөөгөөр ажлын байр нэмэгдсэн
  - Манай орон нутагт боловсруулах үйлдвэрүүд баригдсан
  - Манай орон нутагт үр тариа хадгалах агуулах баригдсан
  - Шинээр баригдсан бүтээн байгуулалтын нөлөөгөөр иргэдийн орлого нэмэгдсэн
- Хөтөлбөрийн үр нөлөөг шууд хүртсэн иргэдийн хувьд дараах үр дүнг хүртсэн хэмээн үзэж байна. Үүнд
- Бүтээгдэхүүний стандарт, тохирол баталгаажуулалтын гэрчилгээтэй болсон
  - Хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдсан /ЖДҮДС, ХБ, ОУБ/
  - Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлсэн
  - Бүтээн байгуулалт, өргөтгөл хийгдсэн /үйлдвэр, зоорь, агуулах гм/
  - Ажилчдын нийгмийн асуудалд илүүтэй анхаарах болсон /Ажилчдын орон сууц барих гэх мэт/
  - Цахимаар үйлчилгээ авах болсон /Бүртгэл, мэдээлэл авах, тодорхойлолт бичиг баримт авах гм/

**Шигтгээ 2. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл**

*Манай энэ хавьд ус их муутай, хажуу айл өмнө жил худаг гаргасан тэр худгаас нь гуйж усаа авдаг. Аймаг сумаас гаргаж өгсөн худаг ойр хавьд байдаггүй. Айлууд ихэвчлэн хувиараа худгаа гаргадаг*

*Дорнод аймгийн Чойбалсан сумын малчин өрх 1*

*Улсаас 5 айлын дунд нэг худаг гаргана гээд орон нутагт нэг худаг гаргахаар аль нэг даргынх нь ах дүү нэр дээрээ авчихдаг болохоор иргэд малчид тэндээс нь ус авч чаддаггүй. Энэ асуудлаас болж манай энд зодоон болж байсан. Айлууд ихэвчлэн хувиараа худаг гаргадаг. Ойрын 10 орчим км газар бол худаг ус байхгүй.*

*Дорнод аймгийн Чойбалсан сумын малчин өрх 2*

*Малын эрүүл мэнд хөтөлбөрийн үр дүн хэсэгт: Малчид малдаа эмчийн зааваргүй эм тариа хэрэглэхгүй байх талаарх анхан шатны ойлголттой болсон.*

*Ховд аймгийн ХХААГ мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн*

*Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн хөтөлбөрийн үр дүн хэсэгт: Манай сургуульд тогооч нарт эрүүл хооллолт, давсны хэрэглээ, хүүхдийн хоолны орц, норматив, илчлэг чанарын талаарх сургалтууд явагдсан. Сургалт семинарын хувьд сайн байсан. Гэвч байрны хүүхдүүдийн хоолны илчлэг, тэжээллэг чанарыг сургалтад заасны дагуу хийхэд асуудал тулгардаг. Учир нь хүүхдэд зарцуулах ёстой хоолны төсөв нь илчлэг тэжээлийн хувьд чанартай хоол хийхэд хүрдэггүй.*

*Ховд аймгийн Дөргөн сумын ЕБС –ийн сургалтын менежер*


*Сав баглаа боодол хөтөлбөрийн үр дүн хэсэгт: Манай сургуулийн хүүхдийн ундны хуванцар савыг төмөр саваар сольсон. Хөдөөгийн айлууд эргээд модон хувингаа хэрэглээнд нэтрүүлж байна. Хүмүүс даавуун тор хэрэглэх тал рүү хандаж байна. Гэвч дэлгүүр, үйлчилгээний газрууд гялгар торны хэрэглээг халж чадахгүй байна.*

*Ховд аймгийн Дөргөн сумын ЕБС –ийн сургалтын менежер*

**3.4. Бодлого хөтөлбөрүүдийн үр ашиг**


Бодлого, хөтөлбөрүүдийн үр нөлөө хүртэгчдийн 76.6 хувь нь тус салбарт хэрэгжсэн бодлого, хөтөлбөрүүд үр ашигтай байсан хэмээн үзсэн байна. Энэхүү үр дүнг нарийвчлан үзвэл “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 89 хувь нь үр ашигтай байсан гэж үзэж байгаа бөгөөд тус хөтөлбөр нь хамгийн үр ашигтай хөтөлбөр байсан. Харин “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 34.4 хувь нь тус хөтөлбөрийн үр ашигтай байсан хэмээн үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Бусад хөтөлбөрүүдийн хувьд дунджаар 83 хувийн үзүүлэлттэй байна.

График 16. Бодлого, хөтөлбөрүүдийн үр ашиг



Судалгаанд хамрагдсан иргэдийн 76.6 хувь нь төрөөс “Хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” үр ашигтай байсан хэмээн үзэж байна. Энэхүү үр дүнг нарийвчлан харвал “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 91.7 хувь нь дээрх бодлогыг үр ашигтай байсан гэж үзэж байгаа бол “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 66 хувь нь тус бодлогыг үр ашигтай байсан хэмээн үзэж байна.

График 17. Төрөөс “Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” хэр үр ашигтай байсан бэ?



Судалгаанд хамрагдсан үр нөлөө хүртэгчдийн 87.5 хувь нь төрөөс “Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” үр ашигтай байсан хэмээн үзэж байна. Тэднийг хөтөлбөр тус бүрээр нарийвчлан харвал “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 93.6


хувь нь дээрх бодлогыг үр ашигтай байсан хэмээн үзсэн нь хөтөлбөрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалсан байж болохоор байна.

График 18. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр үр ашигтай байсан бэ?



Төрөөс хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрүүдийн үр нөлөөг хүртсэн иргэдийн үр ашгийн үнэлгээг хөтөлбөр тус бүрээр нь авч үзвэл “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 89 хувь нь тус хөтөлбөрийн үр ашигтай хэмээн үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Тодруулбал тус хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 68.3 хувь нь тус хөтөлбөрийн маш их үр ашигтай байсан гэж үзжээ. Чанарын судалгааны үр дүнгээс харахад “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим үйл ажиллагаа /гоц халдварт өвчний эсрэг урьдчилан сэргийлэх вакцин гэх мэт/ нь олон жилийн турш тогтмол хийгдэж ирсэн тул тус хөтөлбөрийн үр ашгийг илүү сайн гарахад нөлөөлсөн байна. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн хувьд үр нөлөө хүртэгчдийн 34.4 хувь нь үр ашигтай байсан хэмээн үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Үлдсэн гурван үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн дунджаар 83 хувь нь хөтөлбөр тус бүрийг үр ашигтай байсан гэж үзжээ.


График 19. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр үр ашигтай байсан бэ?



### 3.5. Бодлого, хөтөлбөрүүдийн тогтвортой байдал


Судалгаанд хамрагдсан үр нөлөө хүртэгчдийн 72.8 хувь нь тус салбарт хэрэгжсэн бодлого, хөтөлбөрүүд тогтвортой байдлыг хангасан, цаашид хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үргэлжлэх боломжтой хэмээн үзсэн байна. Үүнийг бодлого, хөтөлбөр тус бүрээр нарийвчлан үзвэл “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 88 хувь нь тогтвортой байсан гэж үзэж байгаа бөгөөд хамгийн өндөр үзүүлэлт бол “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 41.9 хувь нь тус хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангасан гэж үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Бусад гурван хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 80 хувь нь хөтөлбөр тус бүр нь тогтвортой байдлыг хангаж ажиллаж байгаа хэмээн үзэж байна.

График 20. Бодлого, хөтөлбөрүүдийн тогтвортой байдал



Судалгаанд хамрагдсан иргэдийн 72.1 хувь нь төрөөс “Хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа цаашид тогтвортой үргэлжлэх боломжтой хэмээн үзэж байна. Хөтөлбөр тус бүрээр нарийвчлан харвал “Сав, баглаа боодол”, “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрүүдийн үр нөлөө хүртэгчдийн дунджаар 79.2 хувь бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэх боломжтой гэжээ.

График 21. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэр тогтвортой байдлыг хангаж ажилласан бэ?



Судалгаанд хамрагдсан иргэдийн 80.0 хувь нь төрөөс “Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” тогтвортой байдлыг бүрдүүлж чадсан хэмээн үзэж байна.

График 22. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэр тогтвортой байдлыг хангаж ажилласан бэ?



Төрөөс хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрүүдийн үр нөлөөг хүртсэн иргэдийн тогтвортой байдлын үнэлгээг хөтөлбөр тус бүрээр нь авч үзвэл “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 88 хувь нь тус хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж чадсан гэж үзэж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бол “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 42 хувь нь тус хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангасан гэж үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Үлдсэн гурван үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн дунджаар 80.7 хувь нь хөтөлбөр тус бүрийг тогтвортой үргэлжлэх хандлагатай хэмээн үзэж ээ.

График 23. Төрөөс салбарт хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэр тогтвортой байдлыг хангаж ажилласан бэ?



### 3.6. Бодлого, хөтөлбөрүүдийн сайн туршлага ба сургамж

Бодлого, хөтөлбөрийн үр нөлөөгөөр бий болсон **сайн сургамжуудын** талаар дор хураангуйлан орууллаа.

- Технологийн хичээлийн хөтөлбөрт хүрээлэн буй орчин болон байгаль орчинд ээлтэй хэрэглээний агуулгыг тусгаж сурагчдад цаасаар хэрхэн уут хийх гэх мэт зүйлсийг ордог. */Ховд аймгийн Манхан сумын ЕБС/*
- Хүнсэнд хэрэглэх савны талаар телевизээр яриад байдаг болохоор манайх өмнө жил зориулалтын савыг авсан. Өмнө нь шар сав хэрэглэж байсан. Одоо тэр саваа хүнсний биш бусад хэрэглээний ус зөөхдөө хэрэглэдэг. */Дорнод аймгийн малчин өрх/*
- Тухайн үед манайх шувууны байраа барьчхаад хүсэлт өгөөд зээл авч 5,000 дэгдээхэй авсан. Манайх яг хэрэгтэй үедээ авсан нь маш том дэмжлэг болсон. */Дорнод аймгийн тахианы аж ахуй/*
- Нэг жилийн өмнө сум хөгжүүлэх сангаас 30 сая төгрөгийн зээл авсан. Авсан зээлээрээ тоног төхөөрөмж авч үйлдвэрлэлээ эхлүүлэх боломж бүрдсэн. */Төв аймгийн Лүн сумын нэхий элдэх өрхийн үйлдвэрлэл/*
- Сургалтад суудаг, жил бүр үзэсгэлэн худалдаанд оролцдог. Үзэсгэлэн худалдаанд орохоор хүмүүст танигдаад бүтээгдэхүүнээ борлуулахад маш том дэмжлэг болдог. */Төв аймгийн Лүн сумын тэмээний аж ахуй эрхлэгч өрх/*
- Манай сургуулийн тогооч нарт эрүүл хооллолт, давсны хэрэглээ, хүүхдийн хоолны орц, норматив, илчлэг чанарын талаарх сургалтууд явагдсан. Сургалт, семинарын хувьд сайн байсан. Гэвч байрны хүүхдүүдийн хоолны илчлэг, тэжээлэг чанарыг сургалтад заасны дагуу хийхэд асуудал тулгардаг. Учир нь хүүхдэд зарцуулах ёстой хоолны төсөв нь илчлэг тэжээлийн хувьд чанартай хоол хийхэд хүрдэггүй. */Ховд аймгийн Дөргөн сумын ЕБС/*
- Манайх үзэсгэлэн худалдаанд сайн ордог. Аймаг, орон нутгаас ч зохион байгуулдаг, улсын хэмжээнд ч зохион байгуулагддаг. Үзэсгэлэн худалдаанд орсноор хүмүүст

танигдах нь хамгийн том давуу тал болдог. Үзэсгэлэн худалдаагаар явж байгаад л хэдэн нийлүүлдэг дэлгүүртэй болсон. */Дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр/*

- Зохиомол хээлтүүлэг бол их давуу талтай цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй ажил. Зохиомол хээлтүүлэг хийснээр бор үнээний үүлдэр угсааг хадгалж үлдэж байна. Манай суманд ихэвчлэн бор үнээ байдаг. */Төв аймгийн Батсүмбэр сум/*
- Манай сумнаас айл бүрд газар өгнө гээд тараасан. Үнээтэй айл газартай байх юм бол ногоон тэжээлээ тарьчихна их давуу талтай. */Төв аймгийн Батсүмбэр сум/*
- Би өөрөө эмнэлгийн гал тогоонд ажилладаг болохоор хүнсний зориулалтын сав, баглаа боодлын талаарх мэдээлэл сайтай. Энэ чиглэлийн сургалтад “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв”-д 2 удаа сууж байсан. */Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын хэрчсэн гурил, бууз баншны өрхийн үйлдвэрлэл эрхлэгч/*

Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад тулгарсан **хүндрэл, бэрхшээл** ба цаашид анхаарах асуудлуудын талаар дор хураангуйлан орууллаа.

- Төрөөс олон төрлийн хөтөлбөр зарлаад явдаг ч тодорхой хэмжээний мөнгөн төсөв байдаггүй. Бид нарт маш олон цаасан бичиг ирдэг ч яг ажиллах гэхээр ямар ч төсөв байхгүй тул хэрэгжүүлж чаддаггүй.
- 2019 онд 60 сая төгрөгийн төсөл бичээд 30 сая төгрөгийн зээл авсан юм. Тиймээс эхний ээлжид тоног төхөөрөмжөө авчихъя гээд хатаах, бутлах, иоджуулах машинуудаа авсан ч одоо болтол хайрцгаас нь ч гаргаагүй, ашиглаагүй байна. Төхөөрөмжөө ашиглах гэхээр хүнсний стандартын үйлдвэрийн байх байхгүй. 60 сая төгрөгөө бүрэн авсан бол үйлдвэрийн байрныхаа газрыг шийдчихсэн, өөрийн хөрөнгөө нэмээд барьчих төлөвлөгөөтэй байсан юм.
- Хөдөө аж ахуйн газраас олон төрлийн хөтөлбөр явуулдаг ч яг юм хийе бүтээе гэж байгаа тодорхой ажилгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хүрэхгүй байна. Ирж байгаа зүйлс нь зарим нэг тодорхой албан тушаалтнуудын ойр орчмын хүмүүст хүрдэг.
- Зээл тусламж олгохдоо дарга нар өөрсдийн үзэл бодол нийлдэг хүмүүстээ өгөх хандлагатай байдаг.
- Тоног төхөөрөмжтэй бол үйлдвэрлэл ихээр хийж орлого нэмэгдэх боломжтой. Гэвч тоног төхөөрөмж авах зээл яг бид нар шиг өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарт олддоггүй. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зээл олгоно гээд тэр зээлд материалаа бүрдүүлээд өгсөн ч авч чадаагүй. Бүтээгүй шалтгаан нь ажил хийдэг, үйлдвэрлэлээ орлогоороо батлах ёстой /1кг бууз зарах юм бол гүйлгээний утга нь буузны мөнгө гэж хийсэн байх ёстой гэх мэт/, барьцаа хөрөнгө хүрээгүй гэх шалтгаануудтай.
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид зээл авах шаардлагаа хангаж чаддаггүй. Жишээ ЖДҮ –ийг дэмжих зээлийг 1 га газар тариалан эрхлэгчид өгнө гээд заасан байдаг. Гэтэл манай суманд 1 га газар тариалан эрхэлдэг ЖДҮ эрхлэгч бараг байхгүй газар тариалангийн бүсүүдэд бол байдаг байх.
- Мал эмнэлгийн салбарын хамгийн хүнд асуудал бол малын эмчийн хүрэлцээ маш муу байна. Сум бүр мал эмнэлгийн тасагтай байх ёстой гэж байгаа ч Дорнод аймгийн хэмжээнд бараг тал нь малын эмчгүй байна.
- Баг, сумаас ямар ч мэдээлэл өгдөггүй болохоор мэдээлэл их дутмаг байдаг.

- Зарим хүмүүс малаа эмчлүүлдэггүй, тариулдаггүй тэдгээр хүмүүст хариуцлага тооцдог болмоор байна.
- Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг зарахад эргэлтийн хөрөнгө гацах асуудал хамгийн хэцүү байдаг. Жишээ нь манайх Оргилд бараагаа өнөөдөр өгөхөд дэлгүүр дээр бид нарын мөнгө бүтэн 2 сар түгжигддэг, 40 сая төгрөгөөр зээл аваад бүтээгдэхүүн гаргачаад бүтээгдэхүүний мөнгөө бүтэн 2 сар хүлээхээр бид нар ямар мөнгөөрөө дараа дараагийн бүтээгдэхүүнээ гаргах билээ. Үйлдвэрлэгчдээ дэмжье гэж байгаа бол яг энэ зарах нөхцөл дээр анхаарах хэрэгтэй. Мөнгөө авъя гэхээр тэгвэл манайд өгөхөө больчих гэж сүрдүүлдэг.
- Одоо нэгэнт эхэлчихсэн энэ жижиг үйлдвэрлэлүүдийг цааш нь явуулах гэж зүтгэнэ. Гэхдээ хамгийн гол зүйл бол үйлдвэрийн байр байхгүй асуудал юм. Хотын зах руу айлуудаас зайдуу үйлдвэрийн зориулалтын газар өгөөд бид нарт үйлдвэрээ барих орон зайг бий болгож өгөхгүй бол үйлдвэрүүд маш хэцүү байдалд байна. Хөдөө орон нутагтаа үйлдвэрийн байраа бариад ажиллах гэхээр зах зээл байхгүй тул хот руу орж ирэхээс өөр ямар ч аргагүй болдог.
- Иргэдээс ноос авахаар НӨАТ төл, И Баримт гарга гэсэн баримтынхаа учрыг олохгүй энэ жил баахан ноос авчихсан. Ер нь жаахан юм хийх гэхээр татварын дарамт бол маш их байна.
- Малчдын өвөлжөө, хаваржаа гээд дуртай газартаа уул уурхайн компаниуд өрөмдөөд ухчихдаг. Малчид малын өвчин, тухайн жилийн өвсний гарц, хур тунадсаа тооцоолж өвөлжих газраа сонгодог ч сонгосон боломжийн газар нь очоод өрөмдөөд цоолоод малчдыг хөөчихдөг болохоор Засгийн газрыг малчдыг дэмжиж байна гэж хэлж чадахгүй.
- Манайх хүнсний зориулалтын усны сав хэрэглэдэг ч шар саваа давхар хэрэглэдэг. Худаг хол мотоциклоор усаа зөөдөг тул шар сав ус зөөхөд хамгийн тохиромжтой байдаг.



**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГО,  
ХӨТӨЛБӨРИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ  
ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ**

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ

Энэхүү бүлэгт бодлого, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлсэн үр нөлөөний талаар орууллаа.


### 4.1. Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улс нь 1990 оны үед төвлөрсөн төлөвлөгөөт зах зээлийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн. Шилжилтийн үеийн улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлыг 1992-1993 оны хооронд эдийн засгийг тогтворжуулах бодлого явуулан, өмч хувьчлал хийж, үнийг чөлөөлөн, гадаад, дотоод худалдааг чөлөөтэй эрхлэх боломжийг бүрдүүлж шинэ бодлого, үйл ажиллагааг явуулан даван туулсан. Ингэснээр Монгол Улсын эдийн засаг тогтворжиж, цаашид хөгжих суурь тавигдсан.

#### 4.1.1. Дотоод эдийн засгийн тойм мэдээлэл

Монгол Улс нь газар зүйн байршлын хувьд 2 томоохон гүрний дунд байршдаг ба 2 том эдийн засгийн уулзвар болж өгдгөөрөө онцлогтой. Монгол Улс нь далайд гарцгүй улс бөгөөд дотоодын үйлдвэрлэл муу хөгжсөн, уул уурхай, хөдөө аж ахуй болон худалдааны салбартаа тулгуурлан хөгжиж буй улс юм.

График 24. Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: ҮСХ

Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг авч үзвэл 2021 оны байдлаар тухайн оны үнээр 44,090.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ нь өмнөх оноос 14.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 13,104.3 мянган төгрөг байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2020 онд COVID-19 цар тахлын нөлөөгөөр буурсан үзүүлэлттэй байсан ч 2021 оноос эргэн сэргэсэн үр дүнтэй байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг бүтцийн хувьд авч үзвэл худалдаа, уул уурхай, олборлолт болон хөдөө аж ахуйн салбар нь нийтдээ 38 орчим хувийг эзэлдэг. Тодруулбал худалдааны салбар 15.7 хувийг, уул уурхай 25.2 хувийг, хөдөө аж ахуй салбар 13.0 хувийг тус тус эзэлж байна. Харин эрүүл мэндийн салбар нь улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 2.3 хувийг бүрдүүлдэг салбар юм.

2021 онд эдийн засаг өсөлттэй байсан ч инфляцын түвшин нь сүүлийн жилүүдэд байгаагүйгээр огцом өссөн байна. Дэлхийн зах зээл дээрх газрын тос, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, хил дамнасан тээвэрлэлт, логистик, хил дээрх саатлууд, дотоодын махны үнийн өсөлт, нийлүүлэлтийн хомсдол зэргээс шалтгаалан инфляцын түвшин 13.4 хувьд хүржээ.

График 25. Инфляцын түвшин




Эх сурвалж: ҮСХ

Улсын төсвийг орлогын хувьд авч үзвэл 2021 оны байдлаар нийт орлого ба тусламжийн дүн 14,225.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 15,598.1 тэрбум төгрөг байсан бөгөөд 1,372.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байжээ.

Монгол Улсын төсвийн орлогын бүтцийг 2021 оны байдлаар авч үзвэл 83.6 хувийг татварын орлого, 10.6 хувийг татварын бус орлого, 1.2 хувийг тусламжийн орлого эзэлж байна. Нийт 14 тэрбум төгрөгийн орлого нь 2020 оноос 4 тэрбум төгрөгөөр 2019 оноос 2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

График 26. Монгол Улсын төсвийн орлого, бүтцээр



Эх сурвалж: ҮСХ

Улсын төсвийн зарлагын бүтэц 2021 оны байдлаар урсгал зардал 81.8 хувийг, хөрөнгийн зардал 19.5 хувийг, эргэж төлөгдөх цэвэр зээл -1.3 хувийг тус тус эзэлж байна. Урсгал зардлын бүтцийг авч үзвэл 36.5 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл

бусад бараа үйлчилгээний зардал, 57.0 хувийг татаас болон бусад урсгал шилжүүлэг, 6.5 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр эзэлжээ.

График 27. Монгол Улсын төсвийн зарлага, бүтцээр




Эх сурвалж: УСХ

Манай улс эдийн засгийн урт болон богино хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдийг баримталдаг бөгөөд 2021-2025 онд Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг баримталж, богино хугацааны эдийн засгийн бодлогыг жил бүр тодорхойлон ажиллаж байна.

#### 4.1.2. Гадаад худалдаа

Монгол Улс нь 193 орчим улстай дипломат харилцаатай, гадаад бодлогын хувьд төвийг сахисан бодлого баримталдаг улс юм.


График 28. Гадаад худалдааны тэнцэл, тэрбум ам.доллар



Эх сурвалж: Монгол банк

2021 онд нийт 150 орчим улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 25 хувиар буюу 3,211 сая ам.доллараар өсөж 16,087 сая ам.долларт хүрсэн байна. Үүнээс нийт экспортын хэмжээ 9.2 сая ам.доллар ба өмнөх оноос 22 хувиар өсөж, импортын хэмжээ 6.8 сая ам.доллар ба өмнөх оноос 29 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 118 сая ам.доллараар өсөж 2,396 сая ам.долларын ашигтай гарсан байна.


График 29. Экспортын бүтэц



*Эх сурвалж: Монгол банк*

2021 оны гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 22 хувиар буюу 1,665 сая ам.доллараар өсөж 9,241 сая ам.долларт хүрчээ. Экспортын өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт голлон нөлөөлөв. Тодруулбал, нийт экспорт 22 хувиар өсөхөд 20 нэгж хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, 1.5 нэгж хувийг аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, 1.1 нэгж хувийг **мал аж ахуйн бүтээгдэхүүний** өсөлт тус тус бүрдүүлж байна.

График 30. Импортын бүтэц



*Эх сурвалж: Монгол банк*


2021 оны гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29 хувиар буюу 1,547 сая ам.доллараар өсөж 6,845 сая ам.долларт хүрэв. Импортын өсөлтийн 12 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 9 нэгж хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 6 нэгж хувийг нефтийн бүтээгдэхүүн, 2 нэгж хувийг аж үйлдвэрийн орцын өсөлт тус тус бүрдүүлж байна.

## 4.2. Монгол Улсын эдийн засагт ХАА-н салбарын үзүүлж буй нөлөө

### 4.2.1. ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзэлж буй хэмжээ

Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг ерөнхийд нь 18 хуваан үзүүлэлтийг тооцоолдог бөгөөд ХАА-н салбар сүүлийн арван жилийн хугацаанд дунджаар Монгол Улсын ДНБ – ний 12.2 хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд манай улсын хувьд ХАА-н салбарын үйлдвэрлэл, ДНБ –д эзлэх хувийг нэмэгдүүлж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхааран ажиллаж байгаа билээ.

График 31. ХАА –н салбарын ДНБ –д эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ


2011 онд ХАА –н салбар нь ДНБ –ийн 10.2 хувийг бүрдүүлж байсан бол 2015 онд тус үзүүлэлт 3.8 пунктээр өсөж сүүлийн 10 жилийн хамгийн дээд үзүүлэлт болох 14 хувьд хүрч байжээ. Тус оноос хойш буурсаар 2017 онд 11 хувьд хүрсэн бол 2018 оноос эхэлж 2021 он хүртэл тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны байдлаар ХАА –н салбар нь Монгол Улсын ДНБ –ийн 13 хувь (5,731.7 тэрбум төгрөг) бүрдүүлсэн байна.

### 4.2.2. ХАА-н салбарт ажиллагсдын мэдээлэл

2021 оны байдлаар Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй 15 –аас дээш насны 1,825.6 сая хүн бүртгэлтэй байна. Тэдгээрийн 52.6 хувь нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа бөгөөд хөдөө аж ахуйн салбарт хамгийн олон буюу нийт 291.7 мянган хүн ажиллаж байна.

Сүүлийн таван жилийн дунджаар нийт ажиллагсдын 26.2 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна. 2017 онд нийт ажиллагсдын 29.0 хувь нь тус салбарт ажиллаж байсан бол энэ үзүүлэлт 2020 он хүртэл тасралтгүй буурсаар 24.0 хувьд хүрсэн байна. 2021 онд 2 пунктээр өсөж 26 хувьд хүрчээ. ХАА –н салбарт ажиллагсдын 56 хувь нь эрэгтэйчүүд байна.


График 32. ХАА -н салбарт ажиллагсдын хувь



Эх сурвалж: ҮСХ

Монгол Улсын дундаж цалингийн хэмжээ 2021 оны байдлаар 1,279.4 мянган төгрөг байгаа бөгөөд салбараар нь хуваан үзвэл уул уурхай, олборлолтын салбар хамгийн өндөр буюу тус салбарт ажилладаг ажиллагч дунджаар 2,997.8 мянган төгрөгийн цалинтай байна. Харин зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчийн дундаж цалин хамгийн бага буюу 801.7 мянган төгрөг байна. Хөдөө аж ахуйн салбарт ажиллагчийн дундаж цалин 1,002.8 мянган төгрөг байгаа нь салбараар нь жагсаавал 21 салбараас 19 –т орж байна.

**График 33. Дундаж цалин, мянган төгрөгөөр**



#### **Эх сурвалж: УСХ**

Монгол Улсын дундаж цалингийн хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд тухайн жилийн төгрөгийн ханшаараа тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. 2017 онд ХАА –н салбарын дундаж цалин нийт дундаж цалингийн 72.2 хувьтай тэнцэж байсан бол энэ үзүүлэлт тогтвортой өссөөр 2021 онд 78.4 хувьд хүрсэн байна.


#### **4.2.3. ХАА-н салбарын голлох үйлдвэрлэлийн тухай**

Монгол Улсын ХАА-н салбарын бүтцийг газар тариалан болон мал аж ахуй хэмээн ангилдаг. Сүүлийн 10 жил малын тоо толгойн хувьд ерөнхийдөө нэмэгдсэн байна.

Тухайлбал, 2012 оны 40.9 сая толгойгоос 2021 онд 67.3 саяд хүртэл нэмэгджээ. Таван хошуу мал тус бүрээр нь авч үзвэл, 2012 оноос 2019 оны хооронд бүгд жигд нэмэгдсэн бөгөөд 2019 онд малын тоо 70.9 сая толгойд хүрсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр дүнд хүрсэн үзүүлэлт юм. 2020 болон 2021 онд малын тоо толгой 2019 оноос ойролцоогоор 3.9 сая болон 3.6 саяар хорогдсон байна.

Сүүлийн 10 жилийн малын тоонд бог мал болох хонь, ямаа дунджаар нийт малын 87 хувийг эзэлж байгаа бол бог мал болох үхэр, адуу, тэмээ нийт мал сүргийн 14 орчим хувийг эзэлж байна.

График 34. Малын тоо, сая.толгой



Эх сурвалж: ҮСХ

Хөдөө аж ахуйн салбарын чухал бүрэлдэхүүн болох мал аж ахуйн салбарын мах, сүү, ноос, ноолуур болон арьсны үйлдвэрлэлийн хэмжээг дараах хүснэгтэд харууллаа. Сүүлийн арван жилийн хувьд (2011-2020 он) тогтвортой өсөлттэй байгаа хандлага ажиглагдсан. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 2011 оноос 2019 онд хүртэл жигд өсөлтөө хадгалсан. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд мөн ижил өсөлтийн хандлагатай байсан хэдий ч 2020 онд өмнөх онтой харьцуулбал 215 мянган тонноор буурсан байна.


Хүснэгт 6. ХАА бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мянгаар

Төрөл	2016	2017	2018	2019	2020
Мах, кг	400,004.7	426,166.0	515,180.6	545,027.0	744,516.0
Сүү, литр	891,513.1	919,496.7	902,400.7	1,074,234.1	859,002.2
Ноос, тонн	27,399.8	30,626.5	33,013.4	33,692.0	-
Ноолуур, тонн	9,449.6	10,247.5	10,945.1	10,944.2	-
Арьс, мян.шир	14,001.2	14,523.4	19,290.6	19,555.8	27,119.0

Эх сурвалж: ҮСХ

2012-2021 онд газар тариалангийн талбайн хувьд үр тариа, буудайн талбай дийлэнх хувийг эзэлж байжээ. 2015 оноос эхлэн тариалсан талбай нь өмнө оноос 151,118 га-аар нэмэгдсэн ба энэхүү өсөлтийг хадгалсан нөхцөл байдал нь 2021 он хүртэл тасралтгүй үргэлжилжээ.


График 35. Тариалсан талбай, мянган га



Эх сурвалж: ҮСХ

Сүүлийн 10 жилийн ургацын хураалтын тоон мэдээнээс харахад 2012 онд 870.4 мянган тонн ургац хураан авч байсан бол 2021 онд 1.2 сая тоннд хүрсэн нь ургац хураалтын хамгийн өндөр түвшинд хүрсэн үзүүлэлт байлаа. Ургац хураалтыг төрлөөр нь авч үзвэл үр тариа хамгийн их хувийг эзэлж байна.

График 36. Ургац хураалт, мянган тонн




Эх сурвалж: ҮСХ

#### 4.2.4. ХАА-н салбарын бүтээгдэхүүний экспортын хэмжээ


2012 оноос 2021 оны бараа бүтээгдэхүүний экспорт 3.3-9.2 сая долларт хүрсэн бол импортын хэмжээ 6.7 сая доллароос 6.8 сая долларт хүрчээ. Монгол Улсын хувьд ХАА-н бүтээгдэхүүний экспорт 2012 онд нийт экспортын 9 хувийг эзэлж байсан бол 2021 онд 16 хувь болж өссөн байна. Харин импортын хувьд 2012 онд нийт импортын 7 хувийг эзэлж байсан бол 2021 онд 6 хувь болж буурчээ.

График 37. Экспорт, импортод ХАА-н үйлдвэрлэлд эзлэх хувь



2020 оны ХАА-ын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нь ойрын таван жилийн хамгийн доод цэгт хүрсэн нь КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан хэмээн таамаглаж болно.

График 38. ХАА-ын эл салбарын экспорт, импортын хэмжээ, мян.доллар




4.3. Бодлого, хөтөлбөрийн үр шим хүртэгчдэд үзүүлсэн үр нөлөө

4.3.1. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө

Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө хүртэгчдийн тал орчим хувьд нь эерэг нөлөө бий болсон гэж үзсэн байна.

Тодруулбал уг бодлого нь хэрэгжсэнээр салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн гэж хариулсан хувь 48.1, иргэдийн орлогод эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн хувь 46.8 хувь, амьдралын чанар, соёлд эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн хувь 50.2 хувь, мөн 38.7 хувь нь хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлсэн гэж тус тус хариулжээ.

**График 39. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө**




Дээрх үр дүнгээс Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа алдаа, оноотой байсан хэдий ч нийгэмд эерэг үр нөлөө бий болгосон болохыг харж болохоор байна.

#### 4.3.2. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө

Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө хүртэгчдийн дийлэнхийн үзэж буйгаар уг бодлогын нөлөөгөөр салбарын хөгжилд ахиц, дэвшил гарсан, иргэдийн орлого болон амьдралын чанар сайжирсан, хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлтүүд гарсан байна.

Харин судалгаанд оролцсон нийт үр нөлөө хүртсэн 10 иргэн тутмын 2 нь чухам ямар үр нөлөө бий болгосон талаар хэлж мэдэхгүй байгаа нь мэдээ, мэдээлэл хангалтгүй байдгаас шалтгаалсан байж болох талтай юм.

**График 40. Төрөөс " Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө**




**4.3.3. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө**

“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн үзэж буйгаар энэхүү хөтөлбөр нь салбарын хөгжилд, иргэдийн орлогод ямар нөлөө үзүүлсэн нь тодорхой биш байна.

Харин уг хөтөлбөрийн нөлөөгөөр зориулалтын сав, баглаа боодол хэрэглэх, ашиглах мэдлэг, мэдээлэл, дадалтай болсон нь амьдралын чанар, соёлд эерэг нөлөө үзүүлж чаджээ. Энэ нь хүрээлэн буй орчинд эргээд сайнаар нөлөөлсөн байна.

**График 41. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө**




Тус хөтөлбөрийн шууд үр шим хүртэгч буюу үйлдвэрлэл эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, нөөц боломж нэмэгдэж, технологи сайжирсан байна.

График 42. Шууд үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө



ДЭМБ-ын санхүүжилтээр “Хордлого судлал, эрдэм шинжилгээний нийгэмлэг”-ээс хүнсний зориулалтаар ашиглаж байгаа хуванцар савны хэрэглээг тандах зорилгоор 2015 онд явуулсан судалгаагаар нийт өрхийн 90 хувь нь хуванцар сав хэрэглэдэг байжээ. Өөрөөр хэлбэл өрхийн хэмжээнд хэрэглэж буй 10 савны 9 нь хуванцар сав байсан байна. Харин энэ үзүүлэлтийг энэ удаагийн үр нөлөөний үнэлгээний судалгааны үр дүнтэй харьцуулахад 3 болж буурсан байгаа нь сайшаалтай хэрэг байлаа. Тодруулбал 2015 онд 9 хуванцар сав хэрэглэдэг байсан өрх хөтөлбөрийн үр нөлөөг шууд бусаар хүртсэн хэдий ч хуванцар савныхаа хэрэглээг багасгаж чадсан байна.

График 43. Нэг өрхийн хэрэглэж буй ахуйн зориулалттай савны тоо



Шууд бусаар үр нөлөө хүртсэн иргэдэд хамгийн ихээр бий болсон сайн дадал нь сав, баглааны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх зөв мэдлэгтэй болсон явдал байлаа.

График 44. Дам үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө




4.3.4. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө

“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн хувьд энэхүү хөтөлбөр нь хангалттай сайн нөлөөг үзүүлээгүй болохыг дараах графикаас харах боломжтой байна.

Тухайлбал салбарын хөгжилд, иргэдийн орлогод, амьдралын чанарт, хүрээлэн буй орчинд яг ямар нөлөө үзүүлсэн талаар мэдэхгүй гэж хариулсан хариултын хувь дийлэнхийг эзэлж байна.

Ерөнхийдөө хөтөлбөрийн хүрээнд бий болсон шинэ үйлдвэрүүд нь тогтмол үйл ажиллагаагаа явуулдаггүй, үйл ажиллагаа явуулж байгаа нь хүрээлэн буй орчноо маш их бохирдуулдаг гэсэн сэтгэгдлүүдийг чанарын судалгаанд оролцогчид нэлээдгүй дурдаж байсан юм.

График 45. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө



Энэхүү хөтөлбөрийн шууд үр нөлөөг хүртсэн үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны хувьд ч төдийлөн ахиц гараагүй болохыг дараах графикаас харах боломжтой.


График 46. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө



#### 4.3.5. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн уг хөтөлбөрийг салбарын хөгжил, иргэдийн орлогод эерэг нөлөө үзүүлсэн гэж үзжээ.

График 47. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө



Үр нөлөө хүртэгчдийн орлого нэмэгдсэн ба үүнтэй холбоотой амьдралын чанар сайжирсан, мэдлэг чадвар нэмэгдсэн нь хөтөлбөрийн гол үр нөлөө байлаа. Өөрөөр хэлбэл малаа

эрүүлжүүлж чадсанаар малын гаралтай бүтээгдэхүүний чанар сайжирч борлуулах боломж нэмэгдсэн байна. Нөгөө талаас хэрэглэгчдийн хувьд элдэв өвчлөлгүй эрүүл малаас гарган авсан бүтээгдэхүүн хэрэглэх сонирхол нэмэгдэж, энэ талаарх мэдлэг сайжирсан нь энэхүү хөтөлбөрийн бас нэгэн чухал үр нөлөө байсан юм.

График 48. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө




4.3.6. “Ноолуур” хөтөлбөрийн үр нөлөө

“Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн дийлэнх нь хөтөлбөрийн хэрэгжилт нь иргэдийн орлогод, амьдралын чанарт, хүрээлэн буй орчинд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй гэж дүгнэж байна.

Харин боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжсэн үйл ажиллагаанууд нь салбарын хөгжилд тодорхой хэмжээнд ахиц дэвшлийг бий болгосон байна.

График 49. “Ноолуур” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө



Үр нөлөө хүртэгчдийн орлого нэмэгдэж бизнесийн орчин таатай болсон нь энэ хөтөлбөрийн бий болгосон хамгийн гол эерэг үр нөлөө байв.


График 50. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө



4.3.7. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө

“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн үзэж буйгаар энэхүү хөтөлбөр нь салбарын хөгжилд, иргэдийн орлогод, амьдралын чанарт, соёлд, хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлж чаджээ.

График 51. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр бий болсон үр нөлөө



Үр нөлөө хүртэгчид орон нутгийнхантайгаа хамтран ажиллаж органик бүтээгдэхүүн тариалж, үйлдвэрлэдэг болсон нь хөтөлбөрийн бий болгосон хамгийн эерэг үр нөлөө байсан.

График 52. Үр шим хүртэгчдэд бий болсон үр нөлөө






## ТАВДУГААР БҮЛЭГ. ҮР НӨЛӨӨ ХҮРТЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Энэхүү бүлэгт үндэсний хэмжээнд хэрэгжсэн бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг хүртэгчдийн төрийн үйлчилгээнд өгч буй бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүнг орууллаа.

### 5.1. Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ болон GAP шинжилгээ

Үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлохдоо дараах 7 дэд үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг тооцсон.

Зураг 8. Сэтгэл ханамжийг тодорхойлсон үндсэн үзүүлэлтүүд



Судалгааны хүрээнд төрийн үйлчилгээний сэтгэл ханамж болон ач холбогдлыг 1-5 оноогоор хэмжиж судалгаанд оролцогч иргэдийн сэтгэл ханамжийг үнэлсэн. Бодлого, хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн иргэдийн хувьд сэтгэл ханамжийн түвшин дунджаар 3.3 байна. Харин тухайн салбарын үйлчилгээний ач холбогдол нь 4.3 байгаа нь тус салбарын төрийн үйлчилгээ иргэдийн хувьд чухал байдаг ч үйлчилгээгээ хүссэн хэмжээндээ авч чадахгүй байгааг харуулж байна.


График 53. Сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ болон GAP шинжилгээ



Судалгаанд оролцогчдын төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийг хөтөлбөр тус бүрээр нь авч үзвэл хамгийн өндөр сэтгэл ханамжтай байгаа нь “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр байсан бол тус хөтөлбөрийн ач холбогдол нь хамгийн бага буюу 3.9 байна. Сэтгэл ханамж хамгийн багатай хөтөлбөр “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр


байсан бол ач холбогдлын хувьд хамгийн өндөр байгаа нь “Ноолуур”, “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр байв.

**График 54. Сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ болон GAP шинжилгээ, хөтөлбөр тус бүрээр**



Судалгаанд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг дэд үзүүлэлтээр нь ангилан харвал бүх үзүүлэлт иргэдийн хувьд чухал байдаг нь харагдаж байна. Нарийвчлан үзвэл мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байдалтай холбоотой үзүүлэлтүүд хамгийн өндөр ач холбогдлын түвшинтэй байна. Үүний дараа төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал болон албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй орсон байна.

**График 55. Сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ болон GAP шинжилгээ, дэд үзүүлэлтээр**



Сэтгэл ханамжийн хувьд хамгийн бага оноотой дэд үзүүлэлт нь үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой үзүүлэлтүүд байсан бол хамгийн өндөр үнэлэгдсэн нь “Мэдээллийн түгээлт, түүний ойлгомжтой байдал” байна. Гэсэн хэдий ч хамгийн өндрөөр үнэлэгдсэн үзүүлэлт нь сэтгэл ханамжийн түвшний тийм ч өндөр үнэлгээг авч чадаагүй болохыг анхаарах хэрэгтэй.

### 5.1. Үр нөлөө хүртээгчдийн бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаанд өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ

Үр нөлөөний үнэлгээ хийж буй 2 бодлого, 5 хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудыг үр нөлөө хүртээгчдээр үнэлүүлэн, үр дүнг дараах графикт харууллаа.

Үр дүнгээс үзэхэд төрөөс хэрэгжүүлсэн 2 бодлого, 5 хөтөлбөрт иргэд сэтгэл ханамж хангалтай түвшинд биш байгаа бөгөөд 2.6-3.2 онооны хооронд үнэлжээ.

Хэрэгжсэн 2 бодлого, 5 хөтөлбөрөөс хамгийн өндөр сэтгэл ханамжийн үнэлгээг “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр авсан бөгөөд үнэлгээний дүн нь 3.2 байна. Энэ нь үйлчлүүлэгч сэтгэл ханамжтай, гэхдээ хэрэглэгчтэй холбоотой зарим үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай байгааг илэрхийлсэн үр дүн юм.

Харин хамгийн бага үнэлгээг “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр авсан бөгөөд үнэлгээний дүн 2.6 байна. Энэ нь үйлчлүүлэгч сэтгэл ханамж муутай, хэрэглэгчтэй холбоотой нэлээд олон үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай гэсэн утгыг илэрхийлж байгаа юм. Ерөнхийдөө хэрэгжсэн бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаанд үр нөлөө хүртээгчид сэтгэл ханамж багатай байна.

**График 56. Бодлого, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн үнэлгээний нэгтгэл**



Чанарын судалгааны үр дүнгээс харахад тухайн орон нутгийн малын эмч нар малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг хийдэг, дуудлагаар ирээд малаа үзчихдэг тул мал эмнэлийн үйл ажиллагааг сайн гэж иргэд үзэж байна.

## Шигтгээ 3. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл

...Мал эмнэлгийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байдаг. Тарилга, тариагаа хийчихдэг, дуудлагаар ирээд малаа үзчихдэг. Малын эрүүл мэндийн талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь өгөөд явчихдаг.

Дорнод аймгийн малчин өрхийн ярилцлагаас

...Малын тарилга, тариа цаг тухайдаа сайн хийгддэг.

Төв аймгийн Фермийн аж ахуй эрхлэгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

### 5.1.1. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын сэтгэл ханамжийн үнэлгээ

Үр нөлөө хүртэгчдийн хүнс, хөдөө аж ахуйн талаарх бодлогын ерөнхий сэтгэл ханамж 3.0 байна. Үзүүлэлт тус бүрээр нь тодруулан харвал тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийг сайжруулах чиглэлд хийсэн ажлуудад илүү сэтгэл ханамжтай байгаа бол мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийг сайжруулах чиглэлд хийсэн ажлуудад сэтгэл ханамж хамгийн бага байна.

#### График 57. Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ



## Шигтгээ 4. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл

*...Энэ жил тариаланг дэмжих жил болгож зарласантай холбоотой хүнсний ногоо тариалах газрыг батлаад ногоочид хамтран тариалан тарьж байна. Манай сум газар тариалангийн 2 компанитай тэдгээр компаниудтайгаа хамтраад ногоочдоо хоршоо болгох чиглэлээр ажиллаж байна.*

*Дорнод аймгийн Чойбалсан сумын ЗДТГ –ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас*

*...Манайд нэг жил Хятадаас Ногоон пад орж ирсэн юм. Манай сумаас 190 өрх авсан нь иргэддээ хүрсэн ажил байсан. Манай сумын үхрийн тэжээл хадланг бэлдэж байгаа ганц техник тэр л байна.*

*Төв аймгийн Батсүмбэр сумын МАА мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас*

*...Сүү авдаг газар байхгүй. Хөдөө сүүний үйлдвэр хэрэггүй юм шиг байгаа юм. Одоогоос хэдэн жилийн өмнө манай суманд сүүний үйлдвэр баригдсан юм. Одоо тэр үйлдвэрийн дээврийн төмөр нь салхинд урагдаад хөөс нь хийсээд байж байгаа. Нэг ч удаа дотор нь хүн орж байгаагүй...*

*Дорнод аймгийн малчин өрхийн ярилцлагаас*

*... Арьс шир бол шууд хаягдал болж байна. Манай аймагт гэхэд өдөрт доод тал нь 150 малын арьс шир шингэн хаягдал, яс гэх мэт хаягдал гарч байна бүгд хаана хамаагүй хаягдаж байна.*

*Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн*

Чанарын судалгааны үр дүнгээс харахад газар тариалангийн үйл ажиллагаа үйлдвэрлэлтэй холбоотой ажлууд сүүлийн жилүүдэд илүүтэй хийгдэж байгаа төдийгүй энэ нь өрхийн орлогод тодорхой хэмжээний нөлөө үзүүлж байна. Орон нутгийн иргэд хашаандаа өрхийн хэрэглээний ногоо тариалж үлдсэн ногоогоо худалдан борлуулах гэх мэт үр дүнгүүд гарч байгаагаас гадна төрөөс иргэдэд хүлэмж болон бусад техник хэрэгслийг хөнгөлөлттэй зээлээр олгох, тариалангийн газар өмчлүүлэх гэх мэт ажлууд хийж байгаа нь иргэдийн газар тариалангийн чиглэлийн ажилд илүү сэтгэл ханамжтай байхад нөлөөлж байна.

Мал аж ахуйн түүхий боловсруулалтын хувьд өрхүүдийн ихэнх нь малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг уламжлалт аргаар боловсруулалт хийж байгаагаас гадна орон нутагт баригдсан малын гаралтай хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаа муу байна хэмээн үзэж байна. Түүнчлэн малын гаралтай түүхий эд болох арьс шир, ноосны боловсруулалт хийгдэхгүй зарим орон нутагт шууд хог дээр хаягдаж байгаа нь дээрх үзүүлэлтэд нөлөөлж байна.

#### **5.1.2. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын сэтгэл ханамжийн үнэлгээ**

Судалгаанд хамрагдсан төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын үр нөлөө хүртсэн иргэдийн хувьд ерөнхий сэтгэл ханамж 3.0 байна. Үзүүлэлт тус бүрээр нь

тодруулан харвалд аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоход чиглэлд хийсэн ажлуудад илүү сэтгэл ханамжтай байгаа бол худалдааны таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх чиглэлд хийсэн ажлуудад сэтгэл ханамж хамгийн бага байна.

**График 58. Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ**



#### Шигтгээ 5. Үр нөлөө хүртэгчдийн сэтгэгдэл

*...Дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ гээд хилээр арьс ширийг гаргахаа больчихсон юм шиг байна лээ. Одоо айлуудын жалга гуугаар хонины нэхий арьс ширээс их юм байхгүй..*

*Төв аймгийн Батсүмбэр сумын МАА –н мэргэжилтэн*

*...Манайх тахианы махаа борлуулахад хүндрэлтэй байна. Манайхан авч хэрэглэж сураагүй болоод ч тэр юм уу зарагдахгүй л байна.*

*Дорнод аймгийн тахианы АА эрхлэгч*

Чанарын судалгааны үр дүнгээс харахад иргэдийн хувьд тухайн сум орон нутгийн онцлогт тохирсон аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь хамгийн зөв гэж үзсэн бөгөөд одоогийн байдлаар бүтээгдэхүүнээ зарж борлуулахад хүндрэл хамгийн их үүсдэг байна.

### 5.1.3. Хөтөлбөрүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээ

Төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлд боловсруулсан хоёр бодлогын хүрээнд хэрэгжсэн 5 хөтөлбөрийн зорилтот үйл ажиллагаануудад судалгаанд хамрагдсан иргэдийн дундаж сэтгэл ханамж 3.0 байна. Сэтгэл ханамжаас хамгийн өндөр сэтгэл ханамжтай байгаа нь “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (3.2) бөгөөд хамгийн бага сэтгэл ханамжтай нь “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр (2.8) байна.

Хөтөлбөрүүдийн үйл ажиллагаануудыг дээд тал нь 3.7 оноогоор үнэлжээ.

Зорилтуудаас судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд хамгийн сэтгэл ханамжтай байгаа нь “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн “Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах чиглэлд хийсэн ажлууд” байсан бол сэтгэл ханамж хамгийн бага байгаа ажил нь “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн “Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-ложистикийг боловсронгуй болгож, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэн дотоод, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд” байна.

### Хүснэгт 7. Үндэсний хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ

Үндэсний хөтөлбөрийн нэр	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төрөл	Үнэлгээ
"Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөр	Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүй болон бизнесийн таатай таатай орчин бүрдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	3.1
"Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөр	Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах чиглэлд хийсэн ажлууд	2.9
"Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөр	Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.9
"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр	Үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандартыг нэвтрүүлэн нутагшуулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх чиглэлд хийсэн ажлууд	2.6
"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр	Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.6
"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр	Боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, орон нутагт үйлдвэрүүд байгуулах, кластераар хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.6
"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр	Боловсруулах үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага, эрэлтэд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.9

Үндэсний хөтөлбөрийн нэр	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төрөл	Үнэлгээ
"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр	Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-ложистикийг боловсронгуй болгож, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэн дотоод, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.4
"Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр	Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд хийсэн ажлууд	3.1
"Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр	Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах чиглэлд хийсэн ажлууд	3.2
"Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр	Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах чиглэлд хийсэн ажлууд	3.1
"Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр	Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох чиглэлд хийсэн ажлууд	3.1
"Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр	Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	3.1
"Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр	Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах чиглэлд хийсэн ажлууд	3.7
"Ноолуур" үндэсний хөтөлбөр	Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	3.2
"Ноолуур" үндэсний хөтөлбөр	Ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах чиглэлд хийсэн ажлууд	3.2
"Ноолуур" үндэсний хөтөлбөр	Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	3.2
"Ноолуур" үндэсний хөтөлбөр	Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зорилтот зах зээлд чиглэсэн ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх чиглэлд хийсэн ажлууд	3.1
"Ноолуур" үндэсний хөтөлбөр	Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	3.0
"Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөр	Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.9
"Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөр	Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих чиглэлд хийсэн ажлууд	2.9
"Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөр	Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах чиглэлд хийсэн ажлууд	2.8


Үндэсний хөтөлбөрийн нэр	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төрөл	Үнэлгээ
"Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөр	Хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.8
"Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөр	Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлд хийсэн ажлууд	2.5

**5.2. Үр нөлөө хүртэгчдийн төрийн үйлчилгээнд өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ**

**5.2.1. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ**


Судалгаанд хамрагдсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн иргэдийн төрийн байгууллагын үйлчилгээний **сэтгэл ханамжийн үнэлгээ** дунджаар 3.6, ач холбогдол нь 4.1 байна. Сэтгэл ханамж болон ач холбогдлын зөрүү 0.5 байна.

**График 59. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дэд үзүүлэлтүүдээр**




Судалгаанд хамрагдсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн хувьд төрийн үйлчилгээний чанартай холбоотой сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.4, ач холбогдол 4.1 байна. Сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 0.7 байна.

**График 60. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний чанартай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**



“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн хувьд төрийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 3.4 байгаа бол ач холбогдлын үзүүлэлт 4.1 байна. Сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 0.7 байна.


**График 61. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**



Үр шим хүртэгчдийн хувьд төрийн байгууллагын ажилтан албан хаагчидтай холбоотой сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 3.5 байгаа бол ач холбогдлын үзүүлэлт 4.3 байна. Сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 0.8 байна. Нарийвчлан үзвэл нэгж үзүүлэлтүүдээс сэтгэл ханамж хамгийн өндөр байгаа нь ажилтнуудын үнэнч, шударга цаг баримтлах байдалтай холбоотой үзүүлэлт байсан бол сэтгэл ханамж хамгийн багатай үзүүлэлт нь ажилтнуудын үйлчлүүлэгчтэй эрх тэгш харилцах, эелдэг таатай харилцаа хүнд сурталтай холбоотой байна.


Ач холбогдлын хувьд дээрх бүх үзүүлэлт нь ойролцоо үнэлгээтэй байгаа бөгөөд үйлчлүүлэгчтэй эрх тэгш харилцах нь сэтгэл ханамж, ач холбогдлын зөрүү хамгийн өндөртэй үзүүлэлт байна.

**График 62. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Үйлчилгээний орчинтой холбоотой сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 3.3 байгаа бол ач холбогдлын үзүүлэлт 4.0 байна. Сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 0.7 байна. Сэтгэл ханамж хамгийн өндөр байгаа үзүүлэлт нь өрөөнүүдийн хаягжилт байсан бол сэтгэл ханамж хамгийн багатай үзүүлэлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал байлаа.

**График 63. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Судалгаанд хамрагдсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн хувьд мэдээлэл түгээлт түүний ойлгомжтой байхтай холбоотой сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 3.3 байгаа бол ач холбогдлын үзүүлэлт 4.1 байна.

**График 64. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**



Хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн хувьд төрийн байгууллагын ил тод байдалтай холбоотой сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.3 байгаа бол ач холбогдлын дундаж үнэлгээ 4.1 байна.

**График 65. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Сэтгэл ханамж хамгийн өндөртэй нь хүний нөөцийн ил тод байдал байсан бол сэтгэл ханамж хамгийн багатай нь төсөв, санхүүгийн ил тод байдал байна.

### 5.2.2. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ

Судалгаанд хамрагдсан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн иргэдийн төрийн байгууллагын үйлчилгээний сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.2, ач холбогдол нь 4.3 байна. Сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 1.1 байна. Тус хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн төрийн байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт сэтгэл ханамжийн түвшинтэй харьцуулахад өндөр түвшинд байгаагаас харахад үйлчлүүлэгчид хэрэгцээ, хүлээлтдээ нийцсэн үйлчилгээг авч чадаагүй байна.


Дэд үзүүлэлтүүдийн хувьд бүх үзүүлэлтүүд сэтгэл ханамжийн ерөнхий дундажтай ойролцоо түвшин байна.

График 66. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дэд үзүүлэлтүүдээр



Хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн үйлчилгээний чанарт өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ 3.1 байсан ба уг дэд үзүүлэлтийг үнэлсэн 4 нэгж үзүүлэлт ч мөн ойролцоо түвшинд үнэлэгдсэн байна.


График 67. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйл ажиллагааны чанартай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд



Үйлчилгээний хүртээмжийг үнэлсэн дэд үзүүлэлтийг үр шим хүртэгчид 3.2 оноогоор үнэлсэн ба нэгж үзүүлэлтүүд уг үнэлгээтэй ойролцоо түвшинд байна.

Сэтгэл ханамжийн түвшин ач холбогдлоос ихээхэн зөрүүтэй байна.

График 68. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйл ажиллагааны хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд



Судалгаанд хамрагдсан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн хувьд албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 3.3 байгаа бол ач холбогдлын үзүүлэлт 4.5, зөрүү 1.3 байна.


Ерөнхийдөө хөтөлбөрийн үр шим хүртэгчид албан хаагчдаас өндөр хэмжээний соёл, ёс зүйг хүлээж байдаг бол өнөөгийн байдлаар тэдний хүлээлтэд нийцсэн үйлчилгээг үзүүлж хараахан чадахгүй байгааг онцолж байна.

График 69. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд



Үйлчилгээний орчинтой холбоотой сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.1 байгаа бол ач холбогдлын үнэлгээ 4.5, зөрүү 1.4 байна. Нарийвчлан үзвэл сэтгэл ханамж хамгийн өндөр нь байгууллагын гадна, доторх тэмдэг тэмдэглэгээний харагдахуйц байдал болон ерөөнүүдийн хаягжилттай холбоотой байсан.

График 70. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн хувьд



Мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн үнэлгээг 3 нэгж үзүүлэлтийн дунджаар тооцсон бөгөөд дундаж үнэлгээ 3.1 байна.


График 71. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд



Төрийн байгууллагын ил тод байдалтай холбоотой сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.1 байгаа бол ач холбогдлын үнэлгээ 4.4, зөрүү 1.3 байна.

Нарийвчлан үзвэл сэтгэл ханамж хамгийн өндөр үзүүлэлт нь худалдан авах ажиллагааны ил тод байдалтай холбоотой бол сэтгэл ханамж хамгийн багатай нь төсөв санхүүгийн ил тод байдалтай холбоотой байна.


График 72. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд



**5.2.3. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ**


“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.6, ач холбогдол нь 4.0 байна, сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 0.4 байна. Бусад хөтөлбөрүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр сэтгэл ханамжтай байгаа хэдий ч энэ нь хангалттай сайн гэсэн үр дүн биш юм.

График 73. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дэд үзүүлэлтүүдээр




Үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.5, ач холбогдлын түвшин 3.9 байна. Дараах графикт нэгж үзүүлэлтүүдийн үнэлгээг харууллаа.

**График 74. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний чанартай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.3, ач холбогдлын түвшин 3.7 байна.

**График 75. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.6, ач холбогдлын түвшин 3.9 байна.

**График 76. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**



Үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.6, ач холбогдлын түвшин 3.9 байна.

**График 77. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.7, ач холбогдлын түвшин 4.2 байна.

**График 78. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**



Ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.6, ач холбогдлын түвшин 4.1 байна.

График 79. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд




**5.2.4. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ**

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.2, ач холбогдол нь 4.5 байна, сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 1.3 байна.

Дараах графикт харахад тус хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн хүлээлтэд нийцсэн үйлчилгээг өнгөрсөн хугацаанд үзүүлж байгаагүй болохыг харуулж байна.

График 80. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дэд үзүүлэлтүүдээр




Үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.1, ач холбогдлын түвшин 4.5 байна.

**График 81. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний чанартай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.2, ач холбогдлын түвшин 4.5 байна.

**График 82. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.3, ач холбогдлын түвшин 4.6 байна.

**График 83. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**



Үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.2, ач холбогдлын түвшин 4.5 байна.

**График 84. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**




Мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.3, ач холбогдлын түвшин 4.6 байна.

**График 85. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд**



Ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.1, ач холбогдлын түвшин 4.4 байна.


График 86. “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтийн хувьд



**5.2.5. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ**

Судалгаанд хамрагдсан “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн иргэдийн төрийн байгууллагын үйлчилгээний сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.3, ач холбогдол нь 4.4 байна, сэтгэл ханамж ач холбогдлын зөрүү 1.1 байна. Сэтгэл ханамжийн хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй нь мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой үзүүлэлтүүд орж байгаа бол хамгийн бага нь үйлчилгээний хүртээмж, чанартай холбоотой үзүүлэлтүүд байна.

График 87. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, дэд үзүүлэлтүүдээр



Үйлчилгээний чанартай холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.0, ач холбогдлын түвшин 4.3 байна.

График 88. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний чанартай холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд




Үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.0, ач холбогдлын түвшин 4.2 байна.

График 89. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд




Албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.3, ач холбогдлын түвшин 4.4 байна.

График 90. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, албан хаагчийн соёл, ёс зүйтэй холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд




Үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.1, ач холбогдлын түвшин 4.3 байна.

**График 91. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, үйлчилгээний орчинтой холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд**




Мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.1, ач холбогдлын түвшин 4.7 байна.

**График 92. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, мэдээлэл түгээлт, түүний ойлгомжтой байхтай холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд**



Ил тод байхтай орчинтой холбоотой дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.4, ач холбогдлын түвшин 4.4 байна.

График 93. “Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, ил тод байдалтай холбоотой дэд үзүүлэлтүүдийн хувьд



Хүний нөөцийн ил тод байдал үйлчлүүлэгчийн хүлээлтээс давсан байгаа нь сайшаалтай үр дүн болохыг дурдах нь зүйтэй.



## ДҮГНЭЛТ

Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг 1,500 үр шим хүртэгчийг хамруулан гүйцэтгэсэн бөгөөд тэдний 21.5 хувь нь Ховд, 19.8 хувь нь Төв, 22.8 хувь нь Дорнод аймгийн, үлдсэн 35.9 хувь нь Улаанбаатар хотын төлөөлөл байсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрүүдийг орон нутагт хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, журамд нийцүүлэн өөрийн онцлогт тохируулан үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах замаар үйл ажиллагаа хэрэгжүүлж, тодорхой хэмжээний үр нөлөөг иргэд, олон нийтэд хүргэсэн байна.

Бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг дүгнэхийн өмнө сүүлийн жилүүдэд ХАА-н салбарын Монгол Улсын эдийн засагт ямар чухал байр суурь эзэлж байгаа талаар авч үзсэн. Дэлхий дахиныг хамарсан Ковид-19 тахлын үе буюу 2020 оны эхний хагас жилд манай улсын эдийн засаг 9.7 хувиар буурч байжээ. Тодруулбал өмнө дэлхий дахиныг хамарсан 2008-2009 оны санхүүгийн хямралаас үүдэлтэйгээр манай улсын эдийн засаг уналттай гарч байсан бол үүнээс хойш 2019 оны сүүлээс дэлхий дахиныг хамарч буй цар тахлын улмаас эдийн засаг хумигджээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний бууралтын 63.9 хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлсэн бөгөөд уг салбарын уналттай холбоотойгоор худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах салбарууд мөн адил уналтад орсон байна. Харин хөдөө аж ахуйн салбар 1.9 хувийн өсөлттэй гарсан нь уул уурхайн хамаарал давамгайлж буй эдийн засгийг хамгаалах, бэхжүүлэхэд чухал салбар болохоо баталсан үзүүлэлт гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчид бодлого, хөтөлбөрүүдийн ач холбогдлын хувьд “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” болон “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг ач холбогдол хамгийн өндөртэй байсан гэж тодорхойлсон. Харин “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хувьд ач холбогдлын түвшин хамгийн бага байсан.

Бодлого, хөтөлбөрүүдийн үр ашгийн хувьд судалгаанд оролцогчдын 76.6 хувь нь төрөөс “Хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” үр ашигтай, 87.5 хувь нь төрөөс “Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” үр ашигтай байсан гэж үзжээ. Харин хөтөлбөр тус бүрээр нарийвчлан үзвэл “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 89.0 хувь нь үр ашигтай байсан гэж үзэж байгаа бөгөөд “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 34.4 хувь нь тус хөтөлбөрийг үр ашигтай байсан хэмээн үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Бусад хөтөлбөрүүдийн хувьд үр шим хүртэгчдийн дунджаар 83.0 хувь нь үр ашигтай байсан гэж үзсэн байна.

Бодлого, хөтөлбөрүүдийн тогтвортой байдлын хувьд судалгаанд оролцогчдын 72.8 хувь нь тус салбарт хэрэгжсэн бодлого, хөтөлбөрүүд нь тогтвортой байдлыг хангаж ажилласан хэмээн үзэж байна. Бодлого, хөтөлбөр тус бүрээс нь нарийвчлан үзвэл “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн 88.0 хувь нь тогтвортой байдлыг хангаж ажилласан гэж үзэж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт юм. “Ноолуур” үндэсний

хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн 41.9 хувь нь тус хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангасан гэж үзэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Бусад гурван хөтөлбөрүүдийн үр нөлөө хүртэгчдийн 80.0 хувь нь хөтөлбөр тус бүр нь тогтвортой байдлыг хангаж ажиллаж чадсан хэмээн үзэж байна.

Бодлого, хөтөлбөрүүдийн үр нөлөөгөөр өрхийн болоод аж ахуйн бизнесүүд өргөжихийн зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд хувь хүний эрүүл ахуйн болоод хүрээлэн буй орчинд ээлтэй хэрэглээний ойлголтыг авч, хэрэгжүүлж хэвшсэн байгаа нь сайшаалтай үр дүн юм. Харин бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад хөтөлбөрт хамаарах төсвийн хангалтгүй, тодорхойгүй байдал, зарим тохиолдолд анхан шатны нэгжүүдэд бий болоод буй улс төржилтийн улмаас зорилтот бүлэгтээ хүрдэггүй, ЖДҮ эрхлэгчид банк, санхүүгийн байгууллагаас тавих шаардлагыг тэр бүр давдаггүй, мал эмнэлгийн салбарын боловсон хүчний дутагдалтай байдал зэрэг хүндрэл, бэрхшээлүүд нь хэрэгжилтийн үр дүнд нөлөөлсөн болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн голлох ачааг үүрдэг ууган салбарт хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрүүдийн үр шим хүртэгчдэд үзүүлсэн үр нөлөөг бодлого, хөтөлбөр бүрээр дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" хэрэгжсэнээр салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн гэж хариулсан хувь 48.1, иргэдийн орлогод эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн хувь 46.8 хувь, амьдралын чанар, соёлд эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн хувь 50.2 хувь, мөн 38.7 хувь нь хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлсэн гэж тус тус хариулжээ.
- Төрөөс "Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө хүртэгчдийн дийлэнхийн үзэж буйгаар уг бодлогын нөлөөгөөр салбарын хөгжилд ахиц, дэвшил гарсан, иргэдийн орлого болон амьдралын чанар сайжирсан, хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлтүүд гарсан байна. Харин судалгаанд оролцсон нийт үр нөлөө хүртсэн 10 иргэн тутмын 2 нь чухам ямар үр нөлөө бий болгосон талаар хэлж мэдэхгүй байгаа нь мэдээ, мэдээлэл хангалтгүй байдгаас шалтгаалсан байж болох талтай юм.
- "Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн үзэж буйгаар энэхүү хөтөлбөр нь салбарын хөгжилд, иргэдийн орлогод ямар нөлөө үзүүлсэн нь тодорхой биш байна. Харин уг хөтөлбөрийн нөлөөгөөр зориулалтын сав, баглаа боодол хэрэглэх, ашиглах мэдлэг, мэдээлэл, дадалтай болсон нь амьдралын чанар, соёлд эерэг нөлөө үзүүлж чаджээ. Энэ нь хүрээлэн буй орчинд эргээд сайнаар нөлөөлсөн аж. Тус хөтөлбөрийн шууд үр шим хүртэгч буюу үйлдвэрлэл эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, нөөц боломж нэмэгдэж, технологи сайжирсан байгаа нь сайшаалтай.
- "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн хувьд энэхүү хөтөлбөр нь хангалттай сайн нөлөөг үзүүлээгүй байна. Тухайлбал салбарын хөгжилд, иргэдийн орлогод, амьдралын чанарт, хүрээлэн буй орчинд яг ямар нөлөө үзүүлсэн талаар мэдэхгүй гэж хариулсан хариултын хувь дийлэнхийг эзэлж байна. Ерөнхийдөө хөтөлбөрийн хүрээнд бий болсон шинэ үйлдвэрүүд нь тогтмол үйл

ажиллагаагаа явуулдаггүй, үйл ажиллагаа явуулж байгаа нь хүрээлэн буй орчноо маш их бохирдуулдаг гэсэн сэтгэгдлүүдийг чанарын судалгаанд оролцогчдын дийлэнх нь дурдсан байна.

- “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчид уг хөтөлбөрийг салбарын хөгжил, иргэдийн орлогод эерэг нөлөө үзүүлсэн гэж үзжээ. Үр нөлөө хүртэгчдийн орлого нэмэгдсэн ба үүнтэй холбоотой амьдралын чанар сайжирсан, мэдлэг чадвар нэмэгдсэн нь хөтөлбөрийн гол үр нөлөө байлаа. Өөрөөр хэлбэл, малаа эрүүлжүүлж чадсанаар малын гаралтай бүтээгдэхүүний чанар сайжирч борлуулах боломж нэмэгдсэн байна. Нөгөө талаас хэрэглэгчдийн хувьд элдэв өвчлөлгүй эрүүл малаас гарган авсан бүтээгдэхүүн хэрэглэх сонирхол нэмэгдэж, энэ талаарх мэдлэг сайжирсан нь энэхүү хөтөлбөрийн бас нэгэн чухал үр нөлөө байсан юм.
- “Ноолуур” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн дийлэнх нь хөтөлбөрийн хэрэгжилт нь иргэдийн орлогод, амьдралын чанарт, хүрээлэн буй орчинд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй гэж дүгнэж байна. Харин боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжсэн үйл ажиллагаанууд нь салбарын хөгжилд тодорхой хэмжээнд ахиц дэвшлийг бий болгосон байна. Үр нөлөө хүртэгчдийн орлого нэмэгдэж бизнесийн орчин таатай болсон нь энэ хөтөлбөрийн бий болгосон хамгийн гол эерэг үр нөлөө байв.
- “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн үр нөлөө хүртэгчдийн үзэж буйгаар энэхүү хөтөлбөр нь салбарын хөгжилд, иргэдийн орлогод, амьдралын чанарт, соёлд, хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлж чаджээ. Үр нөлөө хүртэгчид орон нутгийнхантайгаа хамтран ажиллаж органик бүтээгдэхүүн тариалж, үйлдвэрлэдэг болсон нь хөтөлбөрийн бий болгосон хамгийн эерэг үр нөлөө байна.

Судалгааны хүрээнд ХХААХҮЯ болон түүний харьяа байгууллагуудын иргэд, олон нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг тодорхойлох зорилгоор сэтгэл ханамжийн үнэлгээг хийсэн. Бодлого, хөтөлбөрийн үр нөлөө хүртсэн иргэдийн хувьд сэтгэл ханамжийн түвшин дунджаар 3.3 байна. Харин тухайн салбарын үйлчилгээний ач холбогдол нь 4.3 байгаа нь тус салбарын төрийн үйлчилгээ иргэдийн хувьд чухал байдаг ч үйлчилгээгээ хүссэн хэмжээндээ авч чадахгүй байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийг хөтөлбөр тус бүрээр нь авч үзвэл хамгийн өндөр сэтгэл ханамжтай байгаа нь “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр төдийгүй тус хөтөлбөрийн ач холбогдол нь хамгийн бага буюу 3.9 байна. Сэтгэл ханамж хамгийн багатай хөтөлбөр “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр байсан бол ач холбогдлын хувьд хамгийн өндөр байгаа нь “Ноолуур”, “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрүүд байв.

Сэтгэл ханамжийн хувьд хамгийн бага оноотой дэд үзүүлэлт нь үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой үзүүлэлтүүд байсан бол хамгийн өндөр үнэлэгдсэн нь “Мэдээллийн түгээлт, түүний ойлгомжтой байдал” байна. Гэсэн хэдий ч хамгийн өндрөөр үнэлэгдсэн үзүүлэлт нь сэтгэл ханамжийн түвшний тийм ч өндөр үнэлгээг авч чадаагүй болохыг анхаарах хэрэгтэй.

## БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Судалгааны үр дүнд үндэслэн төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжсэн бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 8 дугаар хавсралтад тусгагдсан арга зүйн дагуу үнэлж, үр дүнг орууллаа.

Төрөөс “Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын үр нөлөөг дараах хүснэгтээс харна уу.

### Хүснэгт 8. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын үр нөлөө

А. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл	
Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлсэн зорилтот бүлэг болон бусад бүлэг	Бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хууль ёсны эрх ашиг, санхүүгийн боломж, өнөөгийн нөхцөл байдалд нь шууд болон шууд бусаар нөлөөлсөн нийгмийн зорилтот бүлгийг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газрын болон орон нутгийн удирдлагын байгууллага, түүний ажилчид</li> <li>2. Салбарт үйл ажиллагаа эрхлэгч "ХХК", "Хоршоо", "Иргэн", боловсруулах үйлдвэрүүд</li> <li>3. Хэрэглэгч/иргэн</li> <li>4. Малчин болон мал бүхий иргэн</li> <li>5. Худалдаа, үйлчилгээний байгууллагын төлөөлөл /нийтийн хоолны газар, ЕБС, цэцэрлэг, ЭМБ гм/</li> <li>6. Фермерийн үйл ажиллагаа эрхлэгч/Эрчимжсэн аж ахуй эрхлэгч</li> <li>7. Малын эмч</li> <li>8. Хэрэглэгч/иргэн</li> <li>9. Импортын тэжээл болон бусад бүтээгдэхүүн нийлүүлэгч</li> </ol>
Эдийн засгийн хөгжил	Дэлхий дахиныг хамарсан “Ковид-19” тахлын үе буюу 2020 оны эхний хагас жилд манай улсын эдийн засаг 9.7 хувиар буурч байжээ. Тодруулбал өмнө дэлхий дахиныг хамарсан 2008-2009 оны санхүүгийн хямралаас үүдэлтэйгээр манай улсын эдийн засаг уналттай гарч байсан бол үүнээс хойш 2019 оны сүүлээс дэлхий дахиныг хамарч буй цар тахлын улмаас эдийн засаг хумигджээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний бууралтын 63.9 хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлсэн бөгөөд уг салбарын уналттай холбоотойгоор худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах салбарууд мөн адил уналтад орсон байна. Харин хөдөө аж ахуйн салбар 1.9 хувийн өсөлттэй гарсан нь уул уурхайн хамаарал давамгайлж буй эдийн засгийг хамгаалах, бэхжүүлэхэд чухал үр нөлөө үзүүлсэн гэж дүгнэж байна.
Б. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл	
<p><b>Нийгэмд үзүүлсэн нөлөөлөл нь түр зуурын байх, эсхүл урт хугацааны байх эсэхийг дараах байдлаар тодорхойллоо.</b></p> <p>Судалгаанд оролцсон нийт оролцогчдын 72.1 хувь нь төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө цаашид тогтвортой үргэлжлэх боломжтой гэж үзжээ. Өөрөөр хэлбэл бодлогын үр нөлөөгөөр бий болсон өөрчлөлтүүдийг цаашид урт хугацаанд хадгалан үлдэх боломжтой гэж үзсэн оролцогчид дийлэнх хувийг эзэлж байлаа. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• “Зохиомол хээлтүүлэг бол их давуу талтай цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй ажил. Зохиомол хээлтүүлэг хийснээр бор үнээний үүлдэр угсааг хадгалж үлдэж байна. Манай суманд ихэвчлэн бор үнээ байдаг.” /Төв аймгийн Батсүмбэр сум/</li> </ul>	
<p><b>Хүмүүсийн амьдралын хэв маягт үзүүлсэн нөлөөний талаар:</b></p> <p>Төрөөс "Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын үр нөлөө хүртэгчдийн тал орчим хувьд нь эерэг нөлөө бий болсон гэж хариулсан байна.</p> <p><b>Эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн оролцогчдын хариултаас дурдвал:</b></p>	

- “...Хүнсэнд хэрэглэх савны талаар телевизээр яриад байдаг болохоор манайх өмнө жил зориулалтын савыг авсан. Өмнө нь шар сав хэрэглэж байсан. Одоо тэр саваа хүнсний биш бусад хэрэглээний ус зөөхдөө хэрэглэдэг болсон.” /Дорнод аймгийн малчин өрх/
- Амьжиргааны түвшин дээшилсэн
- Үйлдвэрлэлийг дэмждэг болсон
- Хүрээлэн буй орчинд сайн нөлөө үзүүлсэн
- Хүлэмжтэй болж, ногоо тарьдаг болсон
- Малын түүхий эдийг зарж борлуулах боломжтой болсон
- Хөнгөлөлттэй зээл олгож тариаланчдыг дэмждэг болсон
- Мал аж ахуйн гарал үүсэл сайжирсан
- Малын ашиг шим сайжирсан
- Сүүний худалдаа нэг цэгт төвлөрсөн
- Хүнсний аюулгүй байдал нэмэгдсэн
- Хог хаягдал багассан
- Ард иргэд өөрсдөө ногоогоо тариалаад эрүүл хүнс хэрэглэх, хангах хүртээмжтэй болж байна гэх мэт.

**Сөрөг нөлөө үзүүлсэн гэж үзсэн оролцогчдын харуултаас дурдвал:**

- Төрөөс олон төрлийн хөтөлбөр зарлаад явдаг ч тодорхой хэмжээний мөнгөн төсөв байдаггүй. Бид нарт маш олон цаасан бичиг ирдэг ч яг ажиллах гэхээр ямар ч төсөв байхгүй тул хэрэгжүүлж чаддаггүй.
- Хөдөө аж ахуйн газраас олон төрлийн хөтөлбөр явуулдаг ч яг юм хийе бүтээе гэж байгаа тодорхой ажилгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хүрэхгүй байна. Ирж байгаа зүйлс нь зарим нэг тодорхой албан тушаалтнуудын ойр орчмын хүмүүст хүрдэг.
- Зээл тусламж олгохдоо дарга нар өөрсдийн үзэл бодол нийлдэг хүмүүстээ өгөх хандлагатай байдаг.
- Тоног төхөөрөмжтэй бол үйлдвэрлэл ихээр хийж орлого нэмэгдэх боломжтой. Гэвч тоног төхөөрөмж авах зээл яг бид нар шиг өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарт олддоггүй. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зээл олгоно гээд тэр зээлд материалаа бүрдүүлээд өгсөн ч авч чадаагүй. Бүтээгүй шалтгаан нь ажил хийдэг, үйлдвэрлэлээ орлогоороо батлах ёстой /1кг бууз зарах юм бол гүйлгээний утга нь буузны мөнгө гэж хийсэн байх ёстой гэх мэт/, барьцаа хөрөнгө хүрээгүй гэх шалтгаануудтай.
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид зээл авах шаардлагаа хангаж чаддаггүй. Жишээ ЖДҮ –ийг дэмжих зээлийг 1 га газар тариалан эрхлэгчид өгнө гээд заасан байдаг. Гэтэл манай суманд 1 га газар тариалан эрхэлдэг ЖДҮ эрхлэгч бараг байхгүй газар тариалангийн бүсүүдэд бол байдаг байх.
- Мал эмнэлгийн салбарын хамгийн хүнд асуудал бол малын эмчийн хүрэлцээ маш муу байна. Сум бүр мал эмнэлгийн тасагтай байх ёстой гэж байгаа ч Дорнод аймгийн хэмжээнд бараг тал нь малын эмчгүй байна.
- Зарим хүмүүс малаа эмчлүүлдэггүй, тариулдаггүй тэдгээр хүмүүст хариуцлага тооцдог болмоор байна.
- Малчдын өвөлжөө, хаваржаа гээд дуртай газартаа уул уурхайн компаниуд өрөмдөөд ухчихдаг. Малчид малын өвчин, тухайн жилийн өвчний гарц, хур тунадсаа тооцоолж өвөлжих газраа сонгодог ч сонгосон боломжийн газар нь очоод өрөмдөөд цолоод малчдыг хөөчихдөг болохоор Засгийн газрыг малчдыг дэмжиж байна гэж хэлж чадахгүй.
- Салбарын хөгжлийг буруу явуулсан. Амжилттай хэрэгжүүлж чадаагүй буруу байгууллагадаа хөнгөлөлт, урамшуулал олгосон.
- Түүхий эдийн боловсруулалт муу хийгдсэн
- Бэлчээр ашиглалт муу болсон
- Тухайн төвлөрсөн иргэддээ л нөлөө үзүүлсэн
- Ажиллах боловсон хүчингүй болж байна гэх мэт.

**Хүмүүсийн соёлд ямар нөлөө үзүүлсэн (хамтын итгэл, зан үйл, үнэт зүйл, соёл гэх мэт):**

Амьдралын чанар, соёлд эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн хувь 50.2 хувь нь хариулжээ.

**Эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн оролцогчдын хариултаас дурдвал:**

- Би өөрөө эмнэлгийн гал тогоонд ажилладаг болохоор хүнсний зориулалтын сав, баглаа боодлын талаарх мэдээлэл сайтай. Энэ чиглэлийн сургалтад “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв”-д 2 удаа сууж байсан нь ажилдаа болон өрхийн хэрэглээндээ шаардлага хангасан, зориулалтын сав суулгыг ашиглахыг зорьдог болсон. /Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын хэрчсэн гурил, бууз баншны өрхийн үйлдвэрлэл эрхлэгч/
- Манай сургуулийн тогооч нарт эрүүл хооллолт, давсны хэрэглээ, хүүхдийн хоолны орц, норматив, илчлэг чанарын талаарх сургалтууд явагдсан. Сургалт, семинарын хувьд сайн байсан. Гэвч байрны хүүхдүүдийн хоолны илчлэг, тэжээлэг чанарыг сургалтад заасны дагуу хийхэд асуудал тулгардаг. Учир нь хүүхдэд зарцуулах ёстой хоолны төсөв нь илчлэг тэжээлийн хувьд чанартай хоол хийхэд хүрдээгүй. /Ховд аймгийн Дөргөн сумын ЕБС/

**Хүрээлэн буй орчинд ямар нөлөө үзүүлсэн талаар:**

Судалгаанд оролцогчдын 38.7 хувь нь хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлсэн гэж хариулжээ.

**Эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн оролцогчдын хариултаас дурдвал:**

- Технологийн хичээлийн хөтөлбөрт хүрээлэн буй орчин болон байгаль орчинд ээлтэй хэрэглээний агуулгыг тусгаж сурагчдад цаасаар хэрхэн уут хийх гэх мэт зүйлсийг ордог. /Ховд аймгийн Манхан сумын ЕБС/

**В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө****Бодлогыг хэрэгжүүлэх явцад бий болсон хууль, эрх зүйн шинэчлэл:**

1. Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлагад тавигдах шаардлагын тухай олон улсын ISO 16128 стандарт
2. Хүнсний бүх төрлийн будаа, ургамлын тос, малын гаралтай өвс тэжээлийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийг баталсан.
3. “Хөнгөн үйлдвэрлэлийн тухай” хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна.
4. Бүх төрлийн будаа, элсэн чихэр, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах бүх төрлийн малын тэжээлийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.
5. Засгийн газрын 87 -р тогтоол, “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг батлуулсан
6. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.
7. Дархан үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгох ажлын хүрээнд: ЗГ-ын 178 дугаар тогтоол, сайдын А-185 тушаал, 200515/07/165 дугаар бүхий бодлогын гэрээ, ЗГ-ийн 185, 233 дугаар тогтоол гэх мэт эрх зүйн баримт бичгүүдийг батлуулсан.
8. Малын генетик нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх, түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх асуудлыг тусгасан.
9. Засгийн газрын 2018/1/31-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг батлуулсан.
10. 2019 онд “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 87 дугаар тогтоол болон “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг батлуулсан.
11. “Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2020 оны 178 дугаар тогтоолыг батлуулав.
12. “Дархан арьс ширний цогцолбор”-ын хэрэгжүүлэгчид “Гэрээ байгуулах эрх олгох тухай” 2020.05.15-ны өдрийн Сайдын А-185 тушаалыг батлуулав
13. “Дархан арьс ширний цогцолбор” ОНӨХХК-тай 200515/07/165 дугаар бүхий Бодлогын гэрээг 2020.05.15-ны өдөр байгуулав.
14. “Төрийн өмчит компани байгуулах тухай” ЗГ-ын 2020 оны 185 дугаар тогтоолыг батлуулсан.

- 15. “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлах тухай ЗГ-ын 2020 оны 233 дугаар тогтоолыг батлуулсан.
- 16. 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг тус тус үндэслэн “Жагсаалт батлах тухай” ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн.
- 17. 2020 оны Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 232, 233 дугаар тогтоолоор “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпорац” ТӨААТҮГ-ын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, захирлыг батлав.
- 18. 2020 онд Үндэсний Статистикийн Хорооны даргын А/36 тоот тушаалаар албан ёсны статистикийн 27 маягт, БСШУСЯ-ны сайдын А/181 тоот тушаалаар захиргааны статистикийн мэдээллийн 12, бүртгэлийн мэдээллийн 11 маягт, нөхөх зааврыг тус тус шинэчлэн баталсан.

**Г. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлсэн нөлөө**

